



ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ



“ХУУЛЬ ЗҮЙН САЛБАРЫН
ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ” ТӨСӨЛ

КРИМИНОЛОГИ

Гарын авлага

Зөвлөх:

Д.Зүмбэрэлхам

Зохиогчид:

Г. Эрдэнэбат

Б. Батзориг

Г. Туяа

*Энэхүү гарын авлагыг Хууль зүйн яатнаас хэрэгжүүлж буй
Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах”
төслийн хүрээнд боловсруулав.*

Улаанбаатар хот
2013он

DDC
364
K-82

КРИМИНОЛОГИ

Гарын авлага

Гарын авлага боловсруулсан баг:

Зөвлөх:

Д. Зүмбэрэллхам

Зохиогчид:

Г. Эрдэнэбат

Б. Батзориг

Г. Туяа

Хэвлэлийн хуудас: 6.2

Цаасны хэмжээ: B5

Хэвлэсэн тоо: 1200

Хэвлэсэн газар: “BCI” Хэвлэлийн компани

ISBN 978-99962-56-78-3

© Энэхүү гарын авлага зохиогчийн эрхээр хамгаалагдсан тул зөвшөөрөлгүйгээр хэвлэн олшруулахыг хориглоно.



ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН ОЮУТАН, БАГШ НАРТ



Монгол Улсын Засгийн газрын Хууль зүйн салбараа шинэчлэх санаачлагыг анхлан дэмжсэн хандивлагчдын тоонд Дэлхийн банк зүй ёсоор ордог билээ. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2002-2008 онуудад Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн хүрээнд эрх зүйн шинэтгэлийн чухал хэсэг болох Эрх зүйн бакалаврын боловсролын агуулга, чанарыг олон улсын түвшинд нийцүүлж, сайжруулах ажлын эхлэл тавигдсан юм. Тухайлбал, “Эрх зүйн дээд боловсролын Монгол Улсын стандарт”-ын анхны хувилбар, түүний дагуу 31 хичээлийн жишиг хөтөлбөр, эдгээрээс 14 хичээлийн оюутанд зориулсан гарын авлага зэргийг боловсруулж, сургалтын арга барилыг шинэчлэхэд чиглэсэн ажлууд хийгдсэн. Эдгээр хөтөлбөр, гарын авлагыг 2007-2008 онд эрх зүйч бэлтгэдэг бүх их, дээд сургуулиудын оюутнуудын хүртээл болгосон.

2009 оноос Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж эхэлсэн “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд дээрх ажлын үргэлжлэл болох оюутанд зориулсан нийт 20 гаруй хичээлийн гарын авлага боловсруулах ажил хийгдэж байна. Энэ ажлыг хууль зүйн салбарын нэр хүндтэй, туршлагатай эрдэмтэд, багш нар болон идэвх, санаачлагатай залуу багш нараас бүрдсэн нийт 60 орчим хүний бүрэлдэхүүнтэй баг гүйцэтгэж байна.

*Төслийн зохицуулагч
Большорлоогийн Сафантуяа*

ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР



Боловсрол судлаачид болон багш нар сургалт явуулах үзэл баримтлалыг боловсруулахдаа хоёр янзын хандлагыг баримталж байна. Нэг дэх нь илүү уламжлалт хэлбэрийнх бөгөөд агуулгад чиглэсэн баримтлалыг дагадаг байхад хоёр дахь нь үр дүнд анхаардаг. Агуулгад чиглэсэн хандлагаар бол сургалтын агуулгыг тухайн шинжлэх ухааны мэдлэг, ойлголт тодорхойлдог. Харин үр дүнд чиглэсэн хандлага нь мэдлэгт анхаарахаас гадна суралцагчдын ур чадвар, хандлага үнэт зүйлсийн хөгжилд анхаардаг. 1990-ээд оноос хийсэн эрх зүйн шинэчлэлт нь хууль зүйн их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйг шинэчлэх, боловсронгуй болгохыг шаардсан юм. Хууль зүйн яам, Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төслийн “Хууль зүйн бакалаврын боловсролыг дэмжих” дэд төслийн боловсруулсан сургалтын хөтөлбөр, гарын авлагын шинэлэг тал нь:

- Агуулгад суурилсан хөтөлбөрөөс агуулга, үр дүнд суурилсан хөтөлбөр боловсруулсан.
- Зорилго, хүрэх үр дүнг тодорхой болгосон.
- Онолын мэдлэгийг эзэмшүүлэхийг зорихоос гадна мэргэжлийн чадвар эзэмшүүлэх, үнэт зүйлсийн төлөвшилд нь нөлөөлөх зорилго тавьсанд оршино.

*Төслийн зөвлөх
Ухнаагийн Туяа (Ph.D)*

ЗОХИОГЧИД**Дорждамбын Зүмбэрэллхам**

Монгол Улсаас БНЧУ-д суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд, Хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор

1979-1984 онд ОХУ-ын Мөрдөн байцаагчийн дээд сургуулийг дүүргэж эрх зүйч мэргэжил эзэмшсэн. 2001 онд МУИС-ийн доктрантурт суралцаж Хууль зүйн докторын зэрэг хамгаалсан.

1984-1989 онд Өмнөговь аймгийн Цагдан сэргийлэх ангид жинхэнэ болон ахлах мөрдөн байцаагч, 1989-1992 онд Улсын Мөрдөн байцаах газарт ахлах мөрдөн байцаагч, албаны дарга, 1992-2005 онд Цагдаагийн Академид (одоогийн Хууль сахиулахын их сургууль) ахлах багш, сургалтын албаны дарга, дэд захирал, тэргүүн дэд захирал, 2000-2009 онд Хууль зүйн үндэсний төвд багш, Хууль зүйн үндэсний хүрээлэнд Гэмт явдал судлалын секторын эрхлэгч, 2005-2009 онд Монгол Улсын ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх, 2009-2013 онд Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн даргаар тус тус ажилласан.

Нийтийн эрх зүйн салбар, түүний дотор эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, криминологи, төрийн захиргаа, төрийн албаны чиглэлээр судалгаа хийж олон тооны ном, товхимол туурвиж, эрдэм шилжилгээний өгүүлэл, илтгэл нийтлүүлсэн.

**Бадамын Батзориг**

*Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах котиссар
Хууль зүйн ухааны доктор (Ph.D)*

1994 онд Цагдаагийн дээд сургууль төгсч, 1998 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хууль зүйн магистр, 2012 онд МУИС-д Хууль зүйн ухааны докторын зэрэг тус тус хамгаалсан.

Криминологи, Нотолгооны онол, Судалгаа шинжилгээний ажил хийх арга зүйн чиглэлээр 20 гаруй гарын авлага, нэг сэдэвт бүтээл, сурах бичгийг дангаараа буюу бусадтай хамтран бичсэн. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл бэлтгэх, боловсруулах ажлын хэсэгт оролцсон.



Галын Туяа

Их Засаг Олон Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, докторант, дэд профессор

1998 онд Их Засаг Хууль зүйн дээд сургууль эрх зүйч мэргэжлээр төгсч, 2002 онд Батлан Хамгаалах Их Сургуулийн Хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан.

Криминологи, Эрүүгийн эрх зүйн чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийх арга зүйн чиглэлээр 10 орчим гарын авлага, нэг сэдэвт бүтээл, сурах бичгийн зохиогч болон хамтран зохиогчоор ажилласан.



Ганбатын Эрдэнэбат

Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч

1994 онд Цагдаагийн дээд сургууль, 1997 онд Батлан хамгаалахын Их сургууль, 2000 онд ОХУ-ын Уралын хуулийн академийг тус тус төгссөн. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант.

Криминологи, Эрүүгийн эрх зүй, Харьцуулсан эрх зүйн чиглэлээр дагнан судалгааны ажил эрхэлж 30 гаруй хэвлэлийн хуудас гарын авлага, эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж хэвлүүлжээ. Боловсролын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль болон Шүүхийн багц хуулиуд, Эрүүгийн тогтолцооны шинэчлэлийн багц хуулийн төсөл боловсруулах ажилд оролцсон.

ГАРЧИГ**НЭГ. КРИМИНОЛОГИ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

1. Криминологи хичээлийн тодорхойлолт..... 4
2. Криминологи хичээлийн товч агуулга 7

ХОЁР. КРИМИНОЛОГИ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

ЕРӨНХИЙ АНГИ	16
Сэдэв 1. Криминологийн ойлголт, судлах зүйл, тогтолцоо	16
Сэдэв 2. Гэмт явдал судлал	21
Сэдэв 3. Нуугдмал гэмт явдал судлал	27
Сэдэв 4. Гэмт явдлын шалтгаан, нөхцөл судлал	31
Сэдэв 5. Гэмт бие хүн судлал.....	34
Сэдэв 6. Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажиллагаа судлал	42
Сэдэв 7. Криминологийн судалгааны арга зүй.....	46
Сэдэв 8. Криминологийн прогноз, төлөвлөлт.....	50
ТУСГАЙ АНГИ	54
Сэдэв 9. Хүч хэрэглэсэн гэмт явдал, урьдчилан сэргийлэх арга зам...	54
Сэдэв 10. Шунахай гэмт явдал, урьдчилан сэргийлэх арга зам.....	62
Сэдэв 11. Зохион байгуулалттай гэмт явдал, урьдчилан сэргийлэх арга зам	67
Сэдэв 12. Хүүхдийн гэмт явдал, урьдчилан сэргийлэх арга зам	71



НЭГ.

НЭГ. КРИМИНОЛОГИ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

1. КРИМИНОЛОГИ ХИЧЭЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Хичээлийн нэр:	“Криминологи”
Индекс:	
Кредит цаг:	2
Нийт цаг:	40 (24 цагийн лекц, 8 цагийн семинар, 8 цагийн дасгал)

“Криминологи” хичээлийг судлах хэрэгцээ, шаардлага (үндэслэл)

Эрт дээр үеэс эхэлсэн хүн төрөлхтөний эрүүл энх, тайван амгалан амьдрах мөнхийн эрэл одоо болтол үргэлжилсээр. Нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт явдал хаа байгаагаас үл хамааран хэлбэр дүрсээ өөрчлөн оршдог. Энэхүү гэмт явдал нь нэг улсын хүрээнээс хальж, дэлхий нийтийн асуудал болсон.

Энэ утгаараа эрх зүйч, хууль сахиулагч мэргэжлийг эзэмшиж буй хүн бүрийн зайлшгүй танин мэдэх үзэгдэл нь гэмт явдал.

Аливаа улс орны гадаад, дотоод аюулгүй байдлыг үр дүнтэй хангаж иргэдийнхээ аюулгүй, тайван амьдралыг бүрдүүлэхэд гэмт явдал, түүний шалтгаан нөхцөлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлан үнэлэлт дүгнэлт өгч, бодлого, чиглэлийг тодорхойлох нь зайлшгүй.

Криминологийн хичээлийг судалснаараа урьд нь болон одоо судалж буй хичээлүүдээр олж авсан мэдлэг дээр тулгуурлан нийгмийн сөрөг үзэгдэл, гэмт бие хүн, тэдгээрийн онцлог, үүсэн бий болох хүчин зүйлсийг шинжлэх ухаанч байр сууринаас судлан, түүнд тулгуурлан аливаа шийдвэр (хууль дүрэм батлан гаргах, өөрчлөх, хүчингүй болгох, Эрүүгийн хуулийг амьдрал дээр бодит байдлаар хэрэгжих боломжоор хангах) гаргах ур чадварыг оюутан, сонсогчид эзэмшүүлэх зайлшгүй шаардлагатай.

Хичээлийн зорилго: *Криминологи хичээлийг судалснаар шинжлэх ухааны үндэслэлтэй гэмт явдалтай тэмцэх, нийгмийн хэв журам халгаалах арга зүй эзэмшин, өтгөөлж буй хэрэг, түүний шалтгаан нөхцөл, хэрэгтэн, түүний төлөвшил зэргийг танин мэдэх ур чадвартай болгоход оршино.*

Хичээлийн зорилт

1. Криминологийн судалгааны арга зүйг эзэмших чадвартай болох
2. Гэмт явдал, түүний хоруршиг, шалтгаан нөхцөл, гэмт бие хүн, тэдгээрийн төлөвшилд нөлөөлөх хүчин зүйлсийг судлах ур чадвартай болох
3. Гэмт явдалтай (тодорхой төрлийн гэмт явдал) тэмцэх, урьдчилан сэргийлэх арга замыг төлөвлөж хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж, гүйцэтгэх онол, практикийн ур чадвартай болох
4. Гэмт хэрэг илрүүлэх, яллах, өмгөөлөх, хянан шийдвэрлэх ажиллагаанд криминологийн хичээлээр олж авсан мэдлэг, ур чадварыг ашиглах чадвар эзэмшүүлэх

Залгамж холбоо

Криминологи нь Эрх зүйн фиолсофи, Эрүүгийн эрх зүй, Социологи, Эрх зүйн социологи зэрэг хичээлтэй уялдаа холбоотой судлагдана.

Криминологи хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, цагийн хуваарилалт

Хичээл заах багш, тухайн сургуулийн сургалтын тэргүүлэх чиглэл, оюутны мэргэшин суралцах хүсэл сонирхол, сургалтын хэрэглэгдэхүүний хангамж хүрэлцээг харгалзан сэдвийн сонголт, цагийн хуваарийг хийнэ. Хичээлийн үндсэн сэдэв, тэдгээрийг заах хэлбэр, цагийн хуваарилалтыг жишиг байдлаар гаргалаа. Хуулийн сургуулийн сургалтын онцлогоос хамааран Криминологийн тусгай ангийн сэдэв нь нэмэгдэх эсхүл бие даасан хичээл болон задарч болно.



№	Сэдэв	Хичээл явуулах хэлбэр			Нийт цаг
		лекц	Семинар	Дасгал ажил	
1	Криминологийн ойлголт, судлах зүйл, тогтолцоо	2	-	-	2
2	Гэмт явдал судлал	2	2		4
3	Нуугдмал гэмт явдал судлал	2	-		2
4	Гэмт явдалын шалтгаан, нөхцөл судлал	2	2		4
5	Гэмт бие хүн судлал	2	2		4
6	Гэмт явдалаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ судлал	2	2		4
7	Криминологийн судалгааны арга, арга зүй	2		2	4
8	Криминологийн прогноз, төлөвлөлт	2		2	4
9	Хүч хэрэглэсэн явдал, урьдчилан сэргийлэх арга зам	2		1	3
10	Шунахай гэмт явдал, урьдчилан сэргийлэх арга зам	2		1	3
11	Зохион байгуулалттай гэмт явдал, урьдчилан сэргийлэх арга зам	2		1	3
12	Насанд хүрээгүй хүмүүсийн гэмт явдал, урьдчилан сэргийлэх арга зам	2		1	3
	НИЙТ 40 ЦАГ	24	8	8	40

2. КРИМИНОЛОГИ ХИЧЭЭЛИЙН ТОВЧ АГУУЛГА

СЭДЭВ 1. КРИМИНОЛОГИЙН ОЙЛГОЛТ, СУДЛАХ ЗҮЙЛ, ТОГТОЛЦОО

Сэдвийн товч агуулга: *Криминологийн ойлголт, үүсэл хөгжил, судлах зүйл, тогтолцоо, Криминологи бусад шинжлэх ухааны уялдаа холбоо*

СЭДЭВ 2. ГЭМТ ЯВДАЛ СУДЛАЛ

Сэдвийн товч агуулга: *Гэмт явдал, түүний шинж, хор уршиг
Гэмт явдлын криминологи шинж, түүнийг судлахын ач холбогдол
Гэмт явдал нийгмийн сөрөг үзэгдэл, Гэмт явдал гэмт хэргийн нийлбэр цогц, Гэмт явдал нутаг дэвсгэрийн онцлогоос хамаардаг үзэгдэл*

СЭДЭВ 3. НУУГДМАЛ ГЭМТ ЯВДАЛ СУДЛАЛ

Сэдвийн товч агуулга: *Нуугдмал гэмт явдал, түүний үндсэн шинж, хор уршиг, нуугдмал гэмт явдал бий болоход нөлөөлөх хүчин зүйлс*

СЭДЭВ 4. ГЭМТ ЯВДЛЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ СУДЛАЛ

Сэдвийн товч агуулга: *Гэмт явдлын шалтгаан, нөхцөл, түүнийг судлахын ач холбогдол, гэмт явдлын ангилал
Гэмт явдал зайлшгүй ба санамсаргүй ойлголт, гэмт явдалд нөлөөлөх хүчин зүйлүүдийн талаархи онол сургаалийн онцлог
Гэмт явдалд хохирогчийн нөлөө*

СЭДЭВ 5. ГЭМТ БИЕ ХҮН СУДЛАЛ

Сэдвийн товч агуулга: *Гэмт бие хүний ойлголт, түүнийг судлахын ач холбогдол
Гэмт хэрэгтэн бие хүний криминологи шинж, түүнийг судлахын ач холбогдол*



*Гэмт санаа бодол төлөвших болон гэмт хэрэг үйлдсэний дараах гэмт хэрэгтэн бие хүний онцлог, тэдгээртэй холбогдсон онол, үзэл баримтлал
Гэмт хэрэгтэн бие хүн төлөвшихөд нөлөөлөх хүчин зүйлс*

СЭДЭВ 6. ГЭМТ ЯВДЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛЛАГАА СУДЛАЛ

Сэдвийн товч агуулга: *Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажиллагааны ойлголт, зорилт, төрөл, ангилал, зарчил, урьдчилан сэргийлэх ажиллагааны үр дүнг судлах ажиллагааны онцлог*

СЭДЭВ 7. КРИМИНОЛОГИЙН СУДАЛГААНЫ АРГА, АРГА ЗҮЙ

Сэдвийн товч агуулга: *Криминологийн судалгааны арга, арга зүй аргачлалын ойлголт
Тодорхой төрлийн гэмт явдлыг судлах криминологийн судалгааны аргачлал бий болгох, боловсронгуй болгох*

СЭДЭВ 8. КРИМИНОЛОГИЙН ПРОГНОЗ, ТӨЛӨВЛӨЛТ

Сэдвийн товч агуулга: *Криминологийн прогнозын ойлголт, ач холбогдол, төрөл
Криминологийн прогноз боловсруулах нийтлэг арга
Криминологийн (Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажиллагааны) төлөвлөлтийн ойлголт, ач холбогдол, төрөл
Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажиллагааны төлөвлөгөө бүтэц, агуулга*

СЭДЭВ 9. ХҮЧ ХЭРЭГЛЭСЭН ГЭМТ ЯВДАЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

Сэдвийн товч агуулга: *Хүч хэрэглэсэн гэмт явдал, гэмт хэрэгтэн бие хүн, тэдгээрийн криминологи шинж, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам*

**СЭДЭВ 10. ШУНАХАЙ СЭДЭЛТТЭЙ ГЭМТ ЯВДАЛ,
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ**

Сэдвийн товч агуулга: *Шунахай сэдэлттэй гэмт явдал, гэмт хэрэгтэн бие хүн, тэдгээрийн криминологи шинж, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам*

**СЭДЭВ 11. ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ЯВДАЛ,
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ**

Сэдвийн товч агуулга: *Зохион байгуулалттай гэмт явдал, гэмт хэрэгтэн бие хүн, тэдгээрийн криминологи шинж, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам*

**СЭДЭВ 12. НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮМҮҮСИЙН ГЭМТ ЯВДАЛ,
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ**

Сэдвийн товч агуулга: *Насанд хүрээгүй хүмүүсийн гэмт явдал, гэмт хэрэгтэн бие хүн, тэдгээрийн криминологи шинж, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам*



3. КРИМИНОЛОГИ ХИЧЭЭЛИЙН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Сурах бичиг, гарын авлага

А. Монгол хэлээр:

1. Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилт /мониторингийн судалгаа, ред. Б. Ганхуяг, УБ., 2004.
2. Авхиа. Ж., Гэмт явдал, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудал, УБ., 1997.
3. Авхиа. Ж., Хүний амины эсрэг гэмт хэргүүд, түүнтэй хийх тэмцэл, УБ., 1982.
4. Адъяабазар. Д, Залилан мэхлэх гэмт хэрэг, УБ., 2008.
5. Адъяабазар. Д.,Мафи, УБ., 1999.
6. Адъяабазар. Д., Төрмандах. З., Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үндэс, УБ., 2005.
7. Аккерман. С. Р, Авилга, төр хоёр - шалтгаан, үр, шинэтгэл, УБ., 2007.
8. Алтангэрэл. Ч, Баатар. Ч, Терроризмийн аюул, түүнээс өөрийгөө болон ойр дотныхоо хамгаалах нь, УБ., 2006.
9. Баатаржав. Н. Эрүүгийн ялын урьдчилан сэргийлэх үр нөлөө, түүнийг дээшлүүлэх тухай асуудал, УБ., 1990.
10. Баатаржав. Н., Жаргал. Б., Криминологи, УБ., 2001.
11. Батжав. Л., Гэмт явдал, түүний шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх асуудал, УБ., 2002.
12. Батжав. Л., Криминологийн зарим асуудал, УБ., 2003.
13. Батзориг. Б., Криминологийн прогноз, төлөвлөлт, УБ., 1997.
14. Батзориг. Б., Криминологийн хичээл сурах аргачилсан зөвлөмж, УБ., 1998.
15. Батзориг. Б., Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлах аргачлал, УБ., 1999.
16. Батзориг. Б., Төрмандах. З., Гүйцэтгэх ажлын криминологи, УБ., 2004.
17. Батзориг. Б., Болдбаатар. Б., Насанд хүрээгүй хүмүүсийн дунд криминологийн судалгаа явуулах аргачлал, УБ., 2004.
18. Батзориг. Б., Баясгаланбат. Н., Гантулга. С., Ичинхорлоо. С., Лхагвамаа. Г. Хүн худалдаалах гэмт хэрэг, УБ., 2009.
19. Беккария. Ч, Гэмт хэрэг ба ялын тухай, орос хэлнээс орчуулсан Г. Эрдэнэбат, УБ., 2007.
20. Болдбаатар. Б., Насанд хүрээгүй хүмүүсийн гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, УБ., 2004.
21. Болдбаатар. Б., Насанд хүрээгүй хүмүүсийн гэмт явдлын шалтгаан судлалын асуудалд, УБ., 2004.
22. Болдбаатар. Ж., Хар тамхи, мансууруулах бодистой холбогдсон гэмт хэргийн эрүүгийн эрх зүй, криминологийн асуудал, УБ., 2001.

23. Гаравсүрэн, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил ба цагдаагийн байгууллага, УБ., 2005.
24. ГүнсэнР., Социалист өмчийн эсрэг гэмт явдалтай тэмцэх эрүүгийн эрх зүй, криминологийн асуудлууд, УБ., 1988.
25. Гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаа, УБ., 2005.
26. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга зам, /Монгол хуульч, эмэгтэйчүүдийн холбоо, Соросын сан, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, УБ., 2002.
27. Дашдэмбэрэл. Д., Малын хулгайн гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүй, криминологийн асуудал, УБ., 1989.
28. Долгорсүрэн. Ж. Эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн ажлын зарим асуудал, УБ., 1985.
29. Дугармаа. А, Хүн худалдаалах гэмт хэргийн шийдвэрлэлт: судалгааны тайлан, УБ., 2007.
30. Ёндондэмбэрэл. Р., Насанд хүрээгүйчүүдийн үйлдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх орчин цагийн асуудал, УБ., 1998.
31. Жанцан. Н., Гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ (асуулт, хариулт/ УБ., 1986.
32. Жанцан. Н., Гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх онол, практикийн асуудал, УБ., 1987.
33. Жанцан. Н., Криминологи, УБ., 2002.
34. Жанцан. Н., Криминологи, УБ., 2004.
35. Жанцан. Н., Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэж байгаа гэмт явдлын шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам, УБ., 1984.
36. Жанцан. Н., Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд эцэг, эхийн үүрэг, УБ., 1978.
37. Жанцан. Н., Цэвээннамжил. Ю., Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлье, УБ., 1975.
38. Жанцан. С, Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмтхэргийн эрүүгийн эрх зүй, криминологийн асуудалд, УБ., 2008,
39. Жанцан. С., Гэмт явдал судлал, УБ., 1995.
40. Криминологи, ред. Ж. Авхиа, Г. Совд, УБ., 1975.
41. Криминологи, ред. Н. Жанцан, УБ., 1986.
42. Лодой. Ж., Философи ба шинжлэх ухааны судалгааны арга зүй, УБ., 2002.
43. Лувсандорж. Н., Гэмт хэрэгт хийсэн дүншинжилгээ, УБ., 2004.
44. Лүндаажанцан. Н., Гэмт хэргээс урьдчилан сэргийлье, УБ., 1972.
45. Монголын Криминологийн шинжлэх ухааны зарим чухал асуудал, УБ. 1984
46. Мөнхдорж. Гэмт хэргийн статистик, УБ., 2007
47. Нарангэрэл. С., Монгол улсын эрүүгийн эрх зүй тусгай анги, УБ., 2000.



48. Нарангэрэл. С., Эрх зүйн эх толь бичиг, УБ.,2011.
49. Нямсүрэн. Ч., Гэмт хэргийн виктимологи, УБ., 2006.
50. Отгонсүх. А., Цагдаа, олон нийтийн харилцаа, УБ.,2009.
51. Оюунбадам. Р., Шорон доторх амьдрал, УБ., 2001.
52. Совд. Г., БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс, УБ., 1973.
53. Тажебакед. К., Социалист эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх онол арга зүйн зарим асуудал, УБ., 1988.
54. Тархаашин. Д., Баатар. Я., Гэмт хэрэг судлах статистикийн арга зүй, УБ., 1988.
55. Туяа. Г., Гансүх. Ц, Гэмт явдал судлал,УБ., 2006.
56. Хүрлээ. Л., Гэмт хэргээс урьдчилан сэргийлж бие хүнийг хүмүүжүүлэхэд хөдөлмөрийн хамт олны роль, УБ., 1985.
57. Цэлмэг. Ц., Криминологи, УБ., 2005.
58. Шинэ төрлийн гэмт хэрэг. /ЦЕГ, Хууль зүйн үндэсний төв, УБ., 2005.
59. Шинэ төрлийн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх асуудал сэдэвт онол практикийн бага хуралд хэлэлцсэн илтэлүүдийн эмхтгэл, УБ., 2000.

Б. Гадаад хэл дээр:

1. Антонян. Ю. М., Изучение личность преступника, Москва, 1984.
2. Ганс Иаохим Шнайдер, Криминология, Москва, 1994
3. Герцензон. А., Уголовной закон и личность преступника, Москва, 1968.
4. Джозефа Ф. Шели, Криминология, Москва, 2003.
5. Иншаков. С. М., Зарубежная криминология,Москва, 1997.
6. Хохряков. Г. Ф. ” Криминология” Москва, 1999.
7. Чезаре Ломброзо, Гениальность и помешательство, Ростов на Дону 1997
8. Фокс. В.,Введение криминологию, Москва, 1980.
9. Юрий Щербатых “Искусство обман”Москва, 1999
10. Frank E. Hagan,Introduction to criminology SAGE Publications, Inc. 2011.
11. Freda Adler, Gerhard O. W. Mueller, William S. Laufer, Criminology, 1991.
12. Piers Beirne and James W. Messerschmidt Criminology Oxford University Press. 2006.
13. Sue Titus Reid, Crime and Criminology, Eighth Edition, 1997.

В. Докторын диссертаци

1. Р. Гүнсэн, Улс, хоршооллын хөрөнгийг ашиглан шамшигдуулсан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага, Дэд эрдэмтэн, 1965 он
2. Ж. Авхиа, БНМАУ-д санаатай хүн амины гэмт хэрэгтэй явуулах эрүүгийн эрхийн тэмцэл, Дэд эрдэмтэн, 1968 он
3. Р. Гүнсэн, БНМАУ-д социалист өмчийг эрүүгийн эрхээр хамгаалах нь, Доктор, 1974 он

4. Л. Хүрлээ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хөдөлмөрийн хамт олны үйл ажиллагаа, Дэд эрдэмтэн, 1976 он
5. Ж. Авхиа, БНМАУ-д хүний амь насны эсрэг гэмт хэрэгтэй явуулах тэмцлийн эрүүгийн эрх, криминалогийн асуудлууд, Доктор, 1976 он
6. Д. Дашдэмбэрэл, Малын хулгайн хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх нь, Дэд эрдэмтэн, 1977 он
7. Б. Ламжав, Ардын армид цэргийн алба хаах журмын эсрэг гэмт хэрэгтэй явуулах тэмцэл, Дэд эрдэмтэн, 1978 он
8. Н. Жанцан, Насанд хүрээгүйчүүдийн үйлдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх орчин цагийн асуудал, Дэд эрдэмтэн, 1981 он
9. Р. Ёндондэмбэрэл, Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, Дэд эрдэмтэн, 1981 он
10. К. Тажебакед, Хөдөө аж ахуйн нэгдлийн малыг ашиглан шамшигдуулах гэмт хэргийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга, Дэд эрдэмтэн, 1982 он
11. Н. Баатаржав, Гэмт явдал, түүний шалтгаан судлалын криминалогийн асуудал, Дэд эрдэмтэн, 1985 он
12. С. Жанцан, БНМАУ-д рецидив гэмт явдалтай хийх эрүүгийн эрх зүй-криминалогийн асуудлууд, Доктор /Sc. D. /, 1992 он
13. Х. Доржпалам, Монгол улс дахь замын хөдөлгөөний журам ба авто тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлын журмыг зөрчих гэмт үйлдлийн эрүүгийн эрх зүй, криминалогийн асуудал, /Ph. D. /, 2000 он
14. Д. Адъяабазар, Залилан мэхлэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүй, криминалогийн асуудал, /Ph. D./, 2004 он
15. Л. Батжав, Хээл хахуулийн гэмт хэргийн эрүүгийн эрх зүй, криминалогийн асуудал, /Ph. D./, 2004 он
16. Б. Болдбаатар, Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэж буй хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зам, /Ph. D. /, 2004 он
17. Ц. Амгаланбаяр, Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэж буй гэмт хэргийн талаарх эрүүгийн бодлого, /Ph. D. /, 2004 он
18. О. Зоригт, Авилгалтай тэмцэхэд эрүүгийн эрх зүйн үүрэг, /Ph. D./, 2004 он
19. Д. Мягмарсүрэн, Монголын эрүүгийн албанаас гүйцэтгэх ажлын шугамаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, /Ph. D./, 2005 он
20. К. Женисгүл, Монгол улсын хууль тогтоомжид заасан танхайрах үйлдлийн эрх зүйн болон криминалогийн шинж чанар, /Ph. D./, 2008 он



ХОЁР

КРИМИНОЛОГИ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

ЕРӨНХИЙ АНГИ

СЭДЭВ 1. КРИМИНОЛОГИЙН ОЙЛГОЛТ, СУДЛАХ ЗҮЙЛ, ТОГТОЛЦОО

Сэдвийн зорилго: *Криминологийн талаарх суурь мэдлэг олгоход чиглэгдэнэ.*

Криминологийн ойлголт


Криминологийн үзэл баримтлалын үүсэл нь хүн буруу зөвийг ялган, өөрсдийгөө гэмт халдлагаас хамгаалах оролдлого хийж эхэлсэнтэй уялдуулан үздэг. Энэ нь эхэндээ философи, ёс заншил, амьдралын хэв маяг, байгаль орчин, шашин, бурхантай холбоотой байв.

Криминологийн шинжлэх ухааны үүсэл хөгжлийн эрчимтэй үеийг XVIII зууны сүүл үеэс XIX зууны эхэн гэж томъёолж болно. Шинжлэх ухаанд тавьдаг шалгуур, үзэл баримтлалд нийцэж эхэлсэн үед нь XX зууны хагас.

Криминологи гэдэг нь латин гаралтай “Crimen”- гэмт хэрэг, грек гаралтай “Logis”-судлал, сургаал гэсэн агуулгыг илэрхийлдэг.

Криминологи нь гэмт явдал, түүний хор уршиг, шалтгаан нөхцөл, гэмт хэрэгтэн болон хохирогч бие хүн, тэдний онцлог байдал, төлөвших зүй тогтол, гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажиллагаа, түүний үр дүн зэргийг судлан шинжлэх ухаануудын ололтод тулгуурлан гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга, ажиллагааг боловсруулан хэрэгжүүлэх арга замыг тодорхойлдог шинжлэх ухаан.

Криминологийн онол сургаалийн ангилал



Олонх криминологид криминологи нь үндсэн хоёр сургаалаас бүрддэг гэж үздэг. Үүнд:

1. Беккариагийн бичсэн “Гэмт хэрэг ба ял шийтгэлийн тухай” (1764 /1774/ он) бүтээлээс эхтэй сонгодог сургааль,
2. Ломброзын бичсэн “Гэмт хэрэгтэн хүн” (1896-1897 он) бүтээлээс эхтэй позитивист сургааль юм.

Европын криминологичид дараах байдлаар ангилдаг:

1. Сонгодог онол (Беккариа, Бенгам, Фейербах);
2. Хүн судлалын онол (Ломброз);
3. Социологийн онол (Ферри, Дюркгейм, Сатерленд) гэж ангилдаг.

Криминологийн түүхэнд бий болсон сургаалуудын олон шалгуураар Сатерленд, Кресси нар дараах байдлаар ангилжээ.

Онол	Үүсэл	Тайлбар	Арга
Сонгодог- нэн сонгодог	1765 он	Гедонизи	Практик туршилт хийхгүйгээр
Зураг зүйн	1830 он	Экологи, соёл, хүн амын бүтэц	Газрын зураг, статистик
Эдийн засгийн	1850 он	Эдийн засгийн шалтгаан	Статистик
Хэв шинжийн сургаал 1. Ломброзын 2. Тестчилэх 3. Сэтгэл судлалын	1875 1905 1905	Төрөлхийн гэмт хэрэгтэн оюун ухааны хомсдол эмгэг судлал	Клиник судалгаа, статистик клиник судалгаа, тестийн болон статистик судалгаа клиник ба статистик судалгаа
Нийгмийн болон нийгмийн сэтгэл зүйн	1915	Бүлэг хүмүүс болон нийгмийн үйл явц	Клиник судалгаа, статистик, нийгмийн судалгаа

Джеффри криминологийн анхдагчид гэмт хэрэгтэн, гэмт хэрэг хоёрын алинд гол анхаарлаа хандуулж байгаа байдлаар нь дараах байдлаар ангилжээ.

Гэмт хэрэг	Гэмт хэрэг	
Бенгам	Ломброз	Доэ
Беккариа	Гарофало	Модсли
Монтеро	Ферри	Маканочи
Дюркгейм	Горинг	Тард
Бонгер	Ашаффенберг	Гросс
	Рей	Хевилэнд



АНУ-ын судлаач Вернан Фокс **сонгодог** (гэмт хэргийг хууль зүйн үүднээс хэр ноцтой болохыг үнэлэх), **позитивист** (гэмт хэргийг олон талаас авч үздэг), **америкийн** (гэмт хэргийн шалтгааныг социологийн онолоор тайлбарлах), **нийгмийн хамгааллын** (гэмт хэрэг нь нийгмийн олон үйл явдлаас шалтгаалдаг) онол гэж дөрөв ангилжээ.

Оросын криминологич А. М. Яковлев шашны, рацианаль, хүн судлалын, сэтгэл судлалын гэж ангилсан.

Криминологийн судлах зүйл

Криминологийн объект нь хүн, нийгмийн үзэгдэл юм.

Криминологийн судлах зүйл	<ul style="list-style-type: none"> • Гэмт явдал, түүний хор уршиг • Гэмт явдлын шалтгаан нөхцөл • Гэмт хэргийн хохирогч • Гэмт бие хүн • Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажиллагаа • Тодорхой төрлийн гэмт явдлыг судалж, урьдчилан сэргийлэх
---------------------------	--

Сүүлийн жилүүдэд салбар дундын криминологи үүсч байна. Тухайлбал, шоронгийн криминологи, гүйцэтгэх ажлын криминологи гэх мэтийг дурьдаж болно.

Эндээс үзэхэд криминологи нь гэмт явдлаас урьдчилан сэргийлэх бүхий л шинжлэх ухаантай уялдана.

Криминологийн тогтолцоо

Ерөнхий анги	Тусгай анги
<ul style="list-style-type: none"> • Криминологийн ойлголт, судлах зүйл, тогтолцоо, • Гэмт явдлын ойлголт, түүний хор уршиг, • Гэмт явдлын шалтгаан, нөхцөл, • Гэмт бие хүн, • Гэмт хэргийн хохирогч, • Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажиллагаа, • Криминологийн прогноз, төлөвлөлт 	<p>Тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам.</p> <p>Тухайн цаг хугацаа, нутаг дэвсгэрт үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн ангилал тус бүрээр судална. Түүнчлэн тухайн ангилал нь нарийвчлан задалж судалж болдог. Тухайлбал, Хулгайлах гэмт явдал (халаасны хулгай, машины хулгай, малын хулгай, хил дамнасан малын хулгай, адуу хулгайлах гэх мэт) Түүнчлэн насанд хүрээгүй хүмүүсийн гэмт явдал, рецидив гэмт явдал болон согтуурал ба гэмт явдлын холбооны тухай асуудлыг авч судалж болно.</p>

ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Криминологийн үүсэл, хөгжил?
2. Криминологийн ангиллын онцлогийг тайлбарлана уу.
3. Монголын криминологийн үүсэл, хөгжлийн талаар сурах бичгээс уншиж ярилцана уу.
4. Криминологийн ойлголт объект болон судлах зүйл?
5. Криминологи нь эрх зүйн шинжлэх ухааны салбар болон бусад шинжлэх ухаантай хэрхэн холбогдох талаар ярилцана уу.
6. Криминологийн тогтолцооны онцлог?



СЭДЭВ 2. ГЭМТ ЯВДАЛ СУДЛАЛ

Сэдвийн зорилго: *Гэмт явдал, түүний үндсэн шинж, криминологи шинж, нийгэм үзүүлж буй хор уршгийг тодорхойлох ур чадварыг эзэвшүүлэхэд чиглэгдэнэ.*

Нийгмийн үзэгдлийг дотор нь жирийн үзэгдэл, нийгмийн эерэг үзэгдэл, нийгмийн сөрөг үзэгдэл гэсэн гурван хэсэгт хуваагддаг. Эдгээрээс нийгмийн сөрөг үзэгдэл нь гэмт явдал хэмээх ойлголтыг бүрдүүлдэг.

Гэмт явдлын үндсэн шинж	Нийгмийн үзэгдэл
	Түүхийн үзэгдэл
	Нэг цаг хугацаанд нутаг орны болон зан заншлын онцлогоос хамааран өөрчлөгдөж байдаг
	Харьцангуй олныг хамарсан үзэгдэл
	Нийгэмд аюултай үзэгдэл, үйл явцын цогц

Нэг. Гэмт явдал нь нийгмийн үзэгдэл

Гэмт хэрэг нь хүний бие даасан ухамсартай үйл ажиллагаа, тодорхой бие хүний гэмт зан төлөвийн үр дагавар юм. Ийм учраас аливаа гэмт хэрэг бол зайлшгүй биш тохиолдлын чанартай үзэгдэл юм. Өөрөөр хэлбэл ямар ч гэмт хэргийг урьдаас мэдсэний үндсэн дээр урьдчилан сэргийлж таслан зогсоож болно. Харин нийгмийн үзэгдэл болох гэмт явдлыг бүрмөсөн таслан зогсоох, устгах боломжгүй.

Гэмт явдлын гаралтын байдал, бүтэц, нийгмийн хөгжлийн явцад өөрчлөгдөж ирсэн. Энэ ч утгаар нь түүнийг нийгмийн үзэгдэл гэж үздэг. Нийгэм эдийн засгийн янз бүрийн формацийн үед гэмт явдлын гаралтын байдал, бүтэц, хандлага, шалтгаан, нөхцөл нь өөрчлөгдөж байдаг.

Гэмт явдал нь нийгмийн макро, микро аль ч түвшинд байдаг. Гэр бүл, найз нөхөд, бичил хамт олон, байгууллага, орон нутаг, улс орны түвшинд ч гэмт явдал үүсэх боломжтой.

Хоёр. Гэмт явдал нь түүхэн үзэгдэл

Гэмт явдал түүхэн үзэгдэл болохын хувьд “Гэмт явдал цаг хугацааны хувьд урд байсан, одоо байгаа, цаашид байх” гэсэн үндсэн шинжийг агуулдаг.

Хүмүүсийн ертөнцийг үзэх үзэл байнга өөрчлөгдөхийн хирээр түүнийг даган нийгэм өөрчлөгдөж байдаг. Энэ нь гэмт явдлыг ч өөрчилж байдаг.

Хүний нийгэм байгаа цагт түүх бичигдэж байдаг. Энэ түүхэнд гэмт явдлын түүх ч мөн адил бичигдэнэ.

Зарим талаар тухайн цаг үед олонх (зарим тохиолдолд хүчтэй цөөнх) ямар үйлдэл, эс үйлдэхүйг нийгэмд аюултай гэж үзсэнээр гэмт явдлын мөн чанар тодорхойлогдоно.

Хүй нэгдлийн үед хүмүүс амьдарч байхдаа гал манаж байгаад унтраахыг аюултай гэж үзэж байснаа хүний болон нийгмийн хөгжлийн явцад дайн тулаанд оролцохгүй бол түүнчлэн эзэн ноёндоо захирагдахгүй тушаал шийдвэр биелүүлэхгүй бол шийтгэдэг байжээ.

Монголчуудын хувьд XII зууны үед ихэвчлэн зан заншлын хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд гэмт явдал гэж үзэж байсан, ХҮШ зууны үе шарын шашны нөлөө ихсэж шашны зан үйл зөрчсөн хүмүүсийг шийтгэж, 1930-аад онд социалист чиг баримжаагаар хөгжихөд нь саад болж байсан учир хүмүүсийг лам буюу баян байсан гэдгээр нь шийтгэж байв. 1960-аад оноос наймаачдыг түүнчлэн хүндэтгэн үзэх шалтгаангүй ажил тасалсан хүмүүсийг хүртэл хорьж шийтгэж байв.

Гурав. Гэмт явдал нь нэг цаг хугацаанд нутаг орны болон зан заншлын онцлогоос хамааран өөрчлөгдөж байдаг

Гэмт явдал түүхэн цаг хугацааны явцад өөрчлөгдөхөөс гадна нэг цаг хугацаанд нутаг орны болон зан заншлын онцлогоос хамааран өөрчлөгдөж байдаг.

Урд дурьдсанаар хүний нийгмийн үнэт зүйл, юуг тухайн нийгэмд зөвшөөрөх, үл зөвшөөрөх, таашаан дэлгэрүүлэх нь ямар цаг хугацаанд байгаагаас үл хамааран өөр байдаг. Тухайлбал, лалын шашинтай улсуудад эр нөхрөөсөө өөр хүнээс хүүхэд гаргасныхаа төлөө цаазаар авахуулж байхад, АНУ-д бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхисныхоо төлөө эцэг, эхчүүд шийтгүүлдэг, зарим дайн тулаан бүхий газар нутагт босогчид гэх хүмүүс бусдыг алж хөнөөхийг жирийн үзэгдэл, гавьяат үйл гэж үзэж байхад олонх улсад түүнийг хамгийн ноцтой гэмт хэрэг хэмээн үздэг.

Манай орны хувьд хүн хулгайлахыг хуулиар хориглосон ч зарим аймгуудад эхнэр болох хүнээ түүний зөвшөөрөлгүйгээр хулгайлах заншил хадгалагдсаар байна.

Энэ бол зан заншлын болон эрх зүйн үүднээс гэмт явдлыг нэгэн цаг үед үзэх хандлага өөр байж болдогийг харуулж байна.

Дөрөв. Гэмт явдал нь харьцангуй олныг хамарсан үзэгдэл

Гэмт явдал хэмээх ойлголт нь нийгмийн үнэлэмж тул тэр нь нэг хүний үзэл баримтлал гэхээсээ илүүтэйгээр олонхын хүсэл сонирхлын илэрхийлэл байдаг. Хэдий хуулиар ямар нэгэн үйлдлийг гэмт хэрэг, зөрчил гэж тооцсон ч олонх



түүнийг аюултай гэж үзэхгүй бол түүнийг гэмт явдал хэмээн тооцох нь утгагүй, түүнтэй тэмцэх бүр ч боломжгүй болдог. Тухайлбал, иргэний хөдөлгөөн өрнөж Монгол Улсын хуулиар хориглосон олон гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчлийг үйлдэж байгаа боловч олон нийт тэдний үйлдлийг зөвтгөж байгаа нь шийтгэх боломжийг багасгаж байдаг. Түүхээс харахад тэмцэгчдийн ямар ч үйлдэл эхний үед нийгэмд аюултай гэж тооцогдож байгаад тэд ялбал тэдгээрийн зан үйл бүр эсрэгээр баатарлаг үйл болон харагдах нь бий.

Тав. Гэмт явдал нь нийгэмд аюултай үзэгдэл, үйл явцын цогц

Гэмт явдал нь дан ганц гэмт хэргийн нийлбэр цогц ойлголт биш юм. Гэмт явдал хэмээх олон нийтийн үнэлэмж нь түүхэн цаг хугацаа, нутаг дэвсгэрийн онцлогоос хамааран өөрчлөгдөж байдаг. Иймээс энэ үзэгдлийг бүрдүүлэгч элементүүд нь гэмт хэрэг, захиргааны зөрчил, сахилгын зөрчил, ёс зүйн зөрчил, зан заншлын хэм хэмжээний зөрчил хэлбэрээр илэрдэг. Энэхүү хэлбэр нь тухайн нийгэмд үзүүлж буй хор уршгаасаа хамааран өөрчлөгддөг. Өөрөөр хэлбэл, криминологи гэмт явдлыг гэмт хэрэг болгон хуульчилсан үед нь авч судалдаггүй. Тухайлбал, гэмт явдлын төрөл болох авлига нь албан тушаалын гэмт хэргээс албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээний зөрчил, зарим тохиолдолд эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулаагүй нийгэмд аюултай гэж тооцогддог албан тушаалтны үйлдэл эс үйлдэхүйгээр илэрдэг.

Гэмт явдлыг криминологийн уламжлалт тодорхойлолтоос үзвэл зөвхөн Монгол Улсын эрүүгийн хуульд заасан нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй болох гэмт хэрэг үйлдэж эрүүгийн хариуцлага хүлээх нас болох 14 нас хүрсэн хүмүүсээс үйлдэж байгаа гэмт хэргийн цогц гэж судлах нь учир дутагдалтай. Өөрөөр хэлбэл гэмт явдалд гэмт хэрэг болон нийгэмд аюултай бусад үйл явц хамаардаг. Түүнээс гадна архидалт, янхалдалт, амиа хорлолт зэрэг нийгмийн сөрөг үзэгдлийн мөн чанар, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга замыг криминологи тусгайлан судалдаг.

Гэмт явдал нь нийгэм, орчин тойрондоо ихээхэн их хор уршиг учруулдаг төдийгүй бусад нийгэмд аюултай үзэгдэл, үйл явцын шалтгаан болж байдаг. Түүнчлэн хүмүүсийн сэтгэл санааг тавгүйтүүлэн төрийн хэвийн үйл ажиллагааг ч алдагдуулахад хүргэдэг.

Гэмт явдал гэдэг нь түүхэн цаг хугацаа, нутаг орон, хүмүүсийн үнэт зүйл, зан заншлын онцлогоос хамааран өөрчлөгдөж байдаг өөрийн гэсэн зүй тогтолтой нийгмийн сөрөг үзэгдэл, үйл явцын цогц ойлголт юм.

Гэмт явдлын криминологи шинж

Гэмт явдлын тоон болон чанарын үзүүлэлтийг гэмт явдлын криминологи шинж гэнэ.

Гэмт хэрэг, зөрчлийн хуулийн нэр, бүртгэгдсэн тоон үзүүлэлт, бүртгэсэн жил, улирал, сар, долоо хоног, өдөр, гараг, цаг, шаардлагатай гэж үзвэл тэмдэглэлт өдөр, минутаар болон бусад үзүүлэлтээр гаргаж болно.

Гэмт явдлын бүтэц гэж тухайн нутаг дэвсгэрт бүртгэгдсэн тодорхой гэмт хэрэг зөрчил нь бусад гэмт хэрэг зөрчлийн дунд эзлэх хувийн жин юм. Бүтцийг тоон үзүүлэлт болон хувиар гаргаж болно. Гэмт явдлын бүтцийг бусад нутаг дэвсгэрт бүртгэгдэж буй гэмт хэргүүдийн дунд эзлэх хувийн жинг тодорхойлж болно. Тухайлбал, Хулгайн гэмт хэргийг бусад хороодод бүртгэгдэж байгаа хулгайн гэмт хэргүүдтэй харьцуулсан үзүүлэлтээр гаргах жишээтэй.

Гэмт явдлын түвшин гэдэг нь тодорхой гэмт хэрэг, зөрчлийг ямар нэг үзэгдэл, үйл явцын үзүүлэлттэй харьцуулсан тоон болон чанарын илэрхийлэл юм. Тухайлбал, Монгол Улсад гэмт хэргийн улмаас нэг цагт нэг хүн хулгайд эд зүйлээ алддаг, зуун хүнд гурван гэмт хэрэг ноогдож байна гэх мэт. Түвшинг улс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг хороодод бүртгэгдсэн байгаа гэмт хэргийн тоон үзүүлэлтээр харьцуулан дүгнэлт хийж болно.

Гэмт явдлын хөдөлгөөн гэдэг нь гэмт хэрэг, зөрчлийн төлөв байдал, бүтэц, түвшингийн өөрчлөлт юм. Хөдөлгөөнийг хоёр буюу түүнээс дээш үзүүлэлтээр гаргана. Таван жилээс дээш үзүүлэлтээр хөдөлгөөнийг гаргавал илүү бодитой дүгнэлт гаргах боломжтой.

Гэмт явдлын хор уршиг

Гэмт явдлын хор уршиг гэж гэмт явдлын улмаас бий болох сөрөг үр дагаврыг хэлнэ. Үүнийг тогтоосноор гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ойрын зорилтыг тодорхойлох, гэмт явдлын хор уршгийг олон нийтэд ойлгуулан, тэдний гэмт явдалтай тэмцэх хүсэл эрмэлзлэлийг бий болгоход ашиглаж болно.

Гэмт явдлын хор уршгийг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- Хувь хүнд учрах хор уршиг
- Нийгэмд учрах хор уршиг
- Байгаль, хүрээлэн байгаа орчинд учрах хор уршиг
- Төр болон нийтийн эрх ашигт учрах хор уршиг
- Нийгмийн үнэт зүйл, ёс суртахуунд нөлөөлөх хор уршиг
- Бусад төрлийн гэмт явдалд таатай нөлөө үзүүлэх гэх мэт.



Гэмт явдлын ангилалт:

Монгол Улсад гарч буй гэмт явдлыг халдаж буй объектоор нь:

- Төрийн эсрэг гэмт явдал
- Хүний эрх эрх чөлөөний эсрэг гэмт явдал
- Эд хөрөнгө шударгаар олж авах, өмчлөх, захиран зарцуулах эрхийн эсрэг гэмт явдал
- Байгаль орчны болон түүний баялагийн эсрэг гэмт явдал
- Төрийн захиргааны хэвийн үйл ажиллагааны эсрэг гэмт явдал
- Нийгмийн хэв журам, нийгмийн аюулгүй байдал, хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт явдал
- Цэргийн гэмт явдал гэж ангилж болно.

Гэмт явдлыг гэмт хэрэг үйлдэгсдийн хүсэл зоригийн чиглэл, зорилго, сэдэлтээр:

- Санаатай гэмт явдал
- Болгоомжгүй гэмт явдал
- Шунахайн гэмт явдал
- Хэвийн харилцааны сэдэлттэй хүч хэрэглэсэн гэмт явдал
- Хүч хэрэглэсэн гэмт явдал гэж ангилна.

Субъектээр нь:

- Насанд хүрсэн ба хүрээгүй хүмүүсийн гэмт явдал
- Эмэгтэйчүүдийн гэмт явдал
- Рецидив гэмт явдал
- Зохион байгуулалттай болон мэргэшсэн гэмт явдал
- Шилжин явагчдын гэмт явдал
- Гадаадын иргэдийн гэмт явдал гэх зэргээр ангилна

ХЯНАЛТЫН АСУУЛТ:

- Гэмт явдлын ойлголт, үндсэн шинжийг тодорхой жишээн дээр ярилцана уу.
- Гэмт явдлын ангилал, түүнийг ангилахын ач холбогдол ба шалгуур?
- Гэмт явдлын криминологи шинжийг тодорхойлохын ач холбогдол?
- Гэмт явдлын хор уршигийн ойлголт, түүнийг тодорхойлохын ач холбогдол?
- Гэмт явдлын улмаас хүнд учирдаг хор уршигийг тодорхойлно уу.
- Гэмт явдлын улмаас нийгэмд учирдаг хор уршигийг тодорхойлно уу.
- Гэмт явдлын улмаас төрд учирдаг хор уршигийг тодорхойлно уу.
- Гэмт явдлын бүтэц, хөдөлгөөн, түвшинг тодорхойлохын ач холбогдол?

СЭДЭВ 3. НУУГДМАЛ ГЭМТ ЯВДАЛ СУДЛАЛ

Сэдвийн зорилго: *Нуугдмал явдалын талаар ойлголтой болсоны үндсэн дээр түүнийг тодорхойлох ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.*

Latent crime буюу **нуугдмал гэмт явдал** нь криминологийн нэг чухал судлагдахуун юм. Энэ нь хууль сахиулах байгууллагад албан ёсоор бүртгэгдээгүй боловч бодитойгоор үйлдэгдсэн гэмт хэргийг илэрхийлсэн ойлголт юм.

Аливаа нийгэмд янз бүрийн об'ектив болон субъектив хүчин зүйлсийн нөлөөгөөр гэмт явдал бүртгэгдэхгүй өнгөрөх явдал гардаг бөгөөд мөн цаашлаад бүртгэж авсан гэмт хэргийнхээ тодорхой хувийг илрүүлж, түүнийхээ мөн л заримд нь ял шийтгэл оногдуулж гэмт хэрэгтэй тэмцэх зорилгодоо хүрдэг байна. Ийнхүү нийгэмд бодитойгоор үйлдэгдсэн гэмт хэргийн тун бага хувьд нь хариуцлага тооцдог үзэгдлийг АНУ-ын криминологичид юүлүүрийн үйлчлэл хэмээн нэрлэж, гэмт хэргийн илрүүлэлтийг аль болох өндөр байлгаж, бүртгэж аваагүй өнгөрсөн нуугдмал гэмт явдлын түвшинг тодорхойлж авахыг хичээхийг чухалчилдаг байна.

Монгол улсад сүүлийн 20 гаруй жилийн гэмт хэргийн статистикаас үзвэл жилд бүртгэгдэж буй гэмт хэргийн 60 орчим хувийг хулгайлах гэмт хэрэг эзэлдэг. Харин авилгын гэмт хэрэг тун бага буюу ердөө 1-2 хувийг эзэлж байна. Үүнээс үндэслэн Монгол Улсад авилгын гэмт явдал бага гардаг, гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг хулгайн гэмт явдалтай тэмцэхэд голлон чиглүүлэх ёстой гэж үзвэл томоохон эндүүрэл болох билээ. Харин бид авилгын нуугдмал байдлын түвшинг тодорхойлж эс чадлаа гэхэд баримжаалах ажил хийж чадвал хулгайтай тэмцэхээс дутахгүй хүч хэрэгсэлийг авилгатай тэмцэхэд зарцуулах ёстойгоо олж мэдэх болно.

Гэмт явдлын нуугдмал байдалд нөлөөлөх хүчин зүйлс	
Об'ектив хүчин зүйлс	Суб'ектив хүчин зүйлс
Хүний хүсэл зоригоос шууд хамаарахгүй нуугдмал гэмт явдал бий болж буй хүчин зүйлс.	Хүний хүсэл зоригоос хамааран нуугдмал гэмт явдал бий болж буй хүчин зүйлс.



Нуугдмал гэмт явдлын түвшинг тогтоох зарим арга

Криминологид гэмт явдлын бодит түвшинг тодорхойлохын тулд социологийн судалгааны аргуудыг ашигладаг. Ердийн ажиглалтын аргаас эхлээд ярилцлага, социологийн асуулга явуулах зэрэг аргуудыг ашиглан нийгмийн санаа бодлыг тандаж, бодит байдлыг мэдэж болох аргуудаар хүмүүсийн мэдэж байгаа хэдий ч хууль сахиулах байгууллагад бүртгэгдээгүй гэмт хэргийн тухай мэдээлэл олж авч болдог.

ОХУ-ын эрдэмтэн Исаевын үзсэнээр гэмт хэрэг хүнд ноцтой, нийгмийн аюул өндөр байх тусмаа нуугдмал байх магадлал бага, мөн тэр хэмжээгээр цөөн үйлддэгдэг, гэмт хэргийн дунд эзлэх хувийн жин бага байдаг. Харин хөнгөн, ялимгүй хэргийн гаралт их боловч ялимгүй хэргийг бүртгэж авах нь мөн бага энэ утгаараа нуугдмал байх магадлал өндөр. Ийм байдлаар нэг төрлийн гэмт хэрэг нийгмийн хор аюулын хэмжээгээрээ эрэмблэгдсэн пирамид маягийн бүтэцтэй байдаг. Харин гэмт хэргийн статистик үүнээс өөр дүр зураг харуулж байвал тэр нь хэдий хэмжээний нуугдмал гэмт явдал байгааг баримжаалах боломжийг олгоно гэж үзсэн.

Гэмт явдлын бодит түвшинг тогтооход хэвлэл мэдээллийн хэрэгсэлд гарсан гэмт хэргийн тухай мэдээ мэдээллийн агуулга дүн шинжилгээ хийх арга ашиглах нь бий. Мөн түүнчлэн Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан, хэрэгсэхгүй болгосон хэргийн шинжилгээ, тоо бүртгэлийн харьцуулалт (эмнэлэгийн тусламж авсан хүмүүсийн бүртгэл, эд хөрөнгө г. м), захиргааны зөрчлийн тоо бүртгэлийн харьцуулалт зэрэг гэмт хэргийн талаар мэдээлэл агуулсан үзүүлэлтүүдийг харьцуулан нуугдмал гэмт хэргийн түвшинг баримжаалж болдог.

Гэмт явдлын бодит түвшинг тогтооход ашигладаг нилээд найдвартайд тооцогдох арга бол системийн шинжилгээний арга юм. Нийгмийн үзэгдэл үйл явц бүхэн өөр хоорондын холбоо шүтэлцээтэй байдаг. Системийн шинжилгээний арга зүй бол юмс үзэгдэлийн тэрхүү харилцан уялдаатай шинж чанарт тулгуурлан бодит байдал зүй тогтолыг нээн илрүүлдэг арга зүй юм.

Дээр дурдсан аргууд нь нуугдмал гэмт явдлын түвшинг баримжаалах, аливаа гэмт явдал өсөж буурсан эсэхийг магадлах, таамаглах үйл ажиллагаа юм.

Харин хууль сахиулах ажлын хүрээнд нуугдмал гэмт явдлыг илрүүлэх ажлыг зохион байгуулдаг. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэгтэй тэмцэх ажлын хүрээнд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан, хэрэгсэхгүй болгосон хэрэг материалд дүн шинжилгээ хийж, хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн агуулгад шинжилгээ хийх замаар тодорхой хэргийг шалгах ажиллагаа явуулах зэргээр нуугдмал хэргийг илрүүлэх ажил зохиож болдог байна.

Ялангуяа, энэ хүрээнд нууц далд үйлдэлтэй гэмт хэргийг мөрдөж илрүүлэх тусгай арга зүй боловсруулан хууль сахиулах үйл ажиллагаанд ашиглах,

гүйцэтгэх ажлын арга хэрэгслийн тусламжтайгаар авилга, цагаан захтаны санхүүгийн луйвар, мөнгө угаах, хүн худалдаалах, мансууруулах бодис худалдаалах зэрэг гэмт хэргийн нийгэмд бугшсан нуугдмал гэмт хэргийн сүлжээг илрүүлэх арга хэмжээ үр дүнгээ өгч нуугдмал гэмт явдлыг илрүүлэх болсон.

Манай улсад сүүлийн жилүүдэд авилгын болон хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг үр дүнтэй арга зүй боловсруулан ажиллан тодорхой амжилтад хүрээд байгаа билээ. Тухайлбал, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд цагдаа иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээлэл, эрүүл мэндийн байгууллага, хил хамгаалах байгууллага зэрэг энэ төрлийн гэмт хэргийн талаар мэдэж болох, түүний эсрэг ашиглаж болох бүх талуудын оролцоонд түшиглэсэн олон талт хамтын ажиллагаа зохион явуулж байгаа нь хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэхэд томоохон хувь нэмэр үзүүлээд байна.

Нуугдмал гэмт явдлыг илрүүлэхэд гүйцэтгэх ажил буюу эрүүгийн тагнуулын үйл ажиллагаа тун чухал үүрэгтэй. Чухамхүү нууц далд үйлдэлтэй аливаа хэргийг илрүүлэхэд хойшлуулшгүй эрэн сурвалжлах, мөрдөн мөшгих ажлын арга хэрэгслийг ашигладаг. Гүйцэтгэх ажлын техник хэрэгсэл, арга барилын тусламжтайгаар хууль сахиулах байгууллагад бүртгэгдээгүй олон гэмт хэргийг илрүүлэн бүртгэдэг билээ.

ХЯНАЛТЫН АСУУЛТ:

- Нуугдмал гэмт явдал гэж юу вэ? Нуугдмал гэмт хэрэг болон илрээгүй, түдгэлзүүлсэн гэмт хэргийн ялгаа.
- Нуугдмал гэмт хэргийн түвшин тодорхойлох аргуудыг нэрлэнэ үү.
- Нуугдмал гэмт явдал бий болоход нөлөөлөх объектив, субъектив хүчин зүйлсийг нэрлэн, тайлбарлана уу.



СЭДЭВ 4. ГЭМТ ЯВДЛЫН ШАЛТГААН, НӨХЦӨЛ СУДЛАЛ

Сэдвийн зорилго: *Гэмт явдлын болон тодорхой гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн талаар мэдлэг олох, нийгэм дэх гэмт хэргийн (эрүүгийн) нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, тодорхой хэргийн шалтгаан нөхцөлийг оновчтой тогтоох чадвар эзэмших, аливаа асуудлыг шинжлэхдээ шалтгаан, үндэслэлд тулгуурлах хандлага төлөвших.*

Гэмт явдлын шалтгаан гэдэг нь гэмт явдалд нөлөөлж буй нийгмийн үзэгдэл үйл, явц бол **гэмт явдлын нөхцөл** гэдэг нь гэмт явдалд нөлөөлж буй нөхцөл байдал буюу тодорхой орчин байдаг.

Бүх үзэгдлийн түгээмэл зүй тогтолт холбоо, шалтгаант нөхцөлүүдийн тухай сургаалыг детерминизм буюу шалтгаанчлалын үзэл гэдэг. Криминологчидод энэ нь нэлээд чухал байр суурь эзэлдэг. Учир нь гэмт хэрэг, гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг судлан үзэж, мөн чанарыг таньж мэдсэнээр түүнийг зогсоох, таслах, урьдчилан сэргийлэх арга замыг зөв оновчтой хийх болно. Энэ талаар олон янзын онол үзэл баримтлал байдаг. Тухайлбал:

- Гэмт явдлын шалтгааны генетик онол
- Гэмт явдлын шалтгааны сэтгэл мэдрэлийн концепц
- Клиник криминологи
- Стикмийн онол
- Дефференциал холбооны онол
- Виктимологи чиг хандлага гэх мэт.

Гэмт явдлын шалтгаан нөхцөлийн судлал нь криминологийн болон бусад шинжлэх ухааны хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулдаг онолын төдийгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга замыг боловсруулж, хэрэгжүүлэхэд практик ач холбогдолтой юм.

Криминологид эхэн үедээ гэмт явдлын шалтгааныг дагнан судалж нөхцөл байдлыг орхигдуулах тал байсан. Орчин үед энэ талаар өөр ойлголттой болж шалтгаан, нөхцөл хэмээн судлан үзэж, шалтгаан нь анхдагч уу, нөхцөл нь анхдагч уу, эсвэл давхацмал ойлголт уу гэдэг дээр санал зөрөлдөх болжээ.

Гэмт явдлын шалтгаан нь нийгмийн мөн чанараас хамааралтай гэдэгт судлаачид нэгдсэн ойлголтод хүрсэн боловч түүнийг янз бүрээр тайлбарладаг. Тухайлбал, гэмт явдлын шалтгаан нь нийгмийн тодорхой үзэгдэл, үйл явдлын цогцолбор ойлголт. Гэмт явдлын нөхцөл нь гэмт явдал бий болох буюу гэмт хэрэг үйлдэгдэх таатай орчин юм.

Шалтгаан, нөхцөл хоёрыг тодорхой үзэгдлийн хувьд авч үзвэл адил ойлголт биш боловч харилцан холбоотой байна. Жишээ нь, хаалгаа түгжилгүй орхих нь хулгайчид боломж олгоно. Энэ нь хулгайн гэмт хэрэг гарах шалтгаан болохгүй, харин нөхцөл байх болно. Мөн гэмт явдлын шалтгаан, нөхцөлд задлан шинжилгээ хийхийн тулд хүчин зүйл гэсэн ойлголтыг авч үзэх нь зүйтэй. Хүчин зүйл нь аливаа үр дүн, үзэгдэл, үйлдлийн хурдасгуур болж өгдөг. Энэ нь сөрөг болон эерэг нөлөө үзүүлэх шинж чанартай байна. Тухайлбал, хүн амын суурьшилт, үйлдвэржилт зэрэг нь нийгэм урагшлан хөгжиж байгаагийн нэг шинж, хөгжлийн зүй тогтолт үр дагавар байна. Гэхдээ дээрх хүчин зүйлийг зөв тооцоолж, хүмүүжил, эдийн засгийн зэрэг бусад арга хэмжээг оновчтой авч явуулж чадахгүй бол гэмт явдлын гаралтыг нэмэгдүүлэх үр дагаврыг дагуулдаг ажээ.

Одоо гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг илүү тодорхой, ойлгомжтой таньж мэдэхийн тулд түүний ангилалтын талаар авч үзье.

Гэмт явдлын шалтгааныг онолын үүднээс:

- Нийгмийн объектив, субъектив шалтгаан,
- Гэмт явдлын ерөнхий шалтгаан ба тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан,
- Тодорхой бүлэг гэмт явдлын шалтгаан,
- Шууд ба тойруу шалтгаан,
- Нэг, хоёр, гуравдугаар үечилсэн шалтгаан,
- Гэмт хэрэгтэн бие хүнд хамаарагдах шалтгаан.

Мөн агуулгаар нь:

- Нийгэм-эдийн засгийн,
- Үзэл суртлын,
- Соёл-хүмүүжлийн,
- Нийгэм сэтгэл зүйн гэх зэргээр ангилдаг.

Гэмт явдлын нийгмийн шалтгааны нөлөөллөөр нь:

- Гэмт явдлын шалтгааны нэгдүгээр ангилал,
- Гэмт явдлын шалтгааны хоёрдугаар ангилал,
- Гэмт явдлын шалтгааны гуравдугаар ангилал.



ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Гэмт явдлын шалтгаан, нөхцөлийн ойлголт, түүнийг судлахын ач холбогдол?
2. Гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийн шалтгаан нөхцөл болон гэмт явдлын шалтгаан нөхцөлийн хоорондын уялдаа холбоо?
3. Гэмт явдал болон гэмт хэргийн шалтаг, тохироо, хүчин зүйл, нөхцөл байдлын ойлголт, тэдгээрийн хоорондын харилцан хамаарал?
4. Гэмт явдалд нөлөөлөх хүчин зүйлүүдийн талаархи онол сургаалийн онцлог?
5. Гэмт явдлын шалтгаан нөхцөлийн ангилал.
6. Нийгэм-эдийн засгийн харилцаанаас үүдэлтэй шалтгааныг тодорхойлон ярилцана уу.
7. Үзэл суртлаас үүдэлтэй шалтгааныг тодорхойлон ярилцана уу.
8. Соёл хүмүүжлээс үүдэлтэй шалтгааныг тодорхойлон ярилцана уу.
9. Нийгэм, сэтгэлзүйгээс үүдэлтэй шалтгааныг тодорхойлон ярилцана уу.

СЭДЭВ 5. ГЭМТ БИЕ ХҮН СУДЛАЛ

Сэдвийн зорилго: *Гэмт бие хүний талаар мэдлэг олох; хүн гэмт хэрэгтэн болж төлөвшихөд нөлөөлсөн нөхцөл байдлыг тодорхойлж, тухайлсан хүний зан үйл буюу гэмт хэрэг, эрх зүйн зөрчил болон нийгэмд харш үйлдэл, эс үйлдэхүйд нь үнэлэлт, дүгнэлт өгөх чадвар эзтших; гэмт хэрэгтэн хүний зан төлөв, нийгмийн байдлыг үнэлэх хандлага тогтох.*

Гэмт бие хүн гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн эсхүл гэмт хэрэг үйлдэх эрсдэлтэй бие хүн

Гэмт хэрэг үйлдэхээс өмнөх үеийн буюу гэмт хэрэг үйлдэх эрсдэлтэй бие хүн.

Гэмт хэрэг үйлдсэний дараах бие хүн буюу гэмт хэрэгтэн бие хүн.

Хүн төрөхөөс гэмт хэрэгтэн болж төрдөггүй ч тодорхой орчин, нөхцөл бүрдэхэд гэмт хэрэг үйлдэх зан төлөвүүд илрэн гарч эхэлдэг. Энэхүү эрсдэлтэй орчинд ажиллаж, амьдарч буй хүмүүсийг гэмт хэрэг үйлдэх эрсдэлтэй бие хүн гэдэг. Тухайлбал, багаасаа хулгай хийдэг аав, ээжийн гар дээр өссөн хүүхэд хулгайн гэмт хэрэг үйлдэх эрсдэлтэй болдог бол ямар ч хараа хяналтгүй төрийн албан хаагч авлигад өртөх эрсдэл нэмэгддэг.

Гэмт хэрэг үйлдэгдмэгц л нэгдүгээр асуулт нь “гэмт хэрэгтэн гэж хэн бэ?” гэж эхэлдэг. Бусад тохиолдолд уг этгээд бидний дунд, хажууд, эргэн тойронд маань ажиллаж амьдарч буй жирийн бие хүн байдаг. Тиймээс “бие хүний ерөнхий ойлголтоос гэмт хэрэгтэн хэмээх бие хүний онцлогийг гаргаж ирэх нь зүйтэй.”

Бие хүн гэдэг нь нийгмийн харилцаанд орж тодорхой нэг бүлэг, давхаргад хамаарагдаж буй этгээд. Өөрөөр хэлбэл, өөрийн үйлдлээ ойлгож, түүнийгээ удирах чадвартай, өөрийн үзэл бодол итгэл үнэмшил бүхий, алива нийгмийн харилцаанд хүслээрээ оролцож үр дагавар бий болгогч юм. Мөн нийгмийн харилцааны бүтээгдэхүүн болохын хирээр бие бялдар, оюун санааны талаар өсөж боловсронгуй болж өөрийн гэсэн хүмүүжил, үзэл бодол, авир араншинтай, хувийн онцлогтой болж байдаг байна.

Гэмт хэрэгтэн бие хүн гэдэг нь “бие хүн” гэсэн ерөнхий социологийн “гэмт хэрэгтэн” гэсэн хууль зүйн ойлголтын нэгдэл юм. Үүнийг судлахын зорилго нь амьдралын тодорхой нөхцөлд тухайн хүний зан төрхийн онцлогт тохирсон шийдвэр гаргах, гэмт зан төлөв төлөвших, бие хүн болон түүнийг хүрээлэн буй бичил орчны харилцан үйлчлэлийн механизмыг олж илрүүлэх, энэ үндсэн дээр гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үр ашигтай арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэхэд оршино.



Судлаачид гэмт хэрэгтэн бие хүний шинжийг:

- Гэмт хэрэгтэн бол өөрийн үйл ажиллагаагаа удирдаж, түүний нийгмийн ашиг сонирхол мөн чанарыг бүрэн тайлбарлаж, хариуцах чадвартай, эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрсэн байна.
- Нийгэмд харш үзэл бодол ямар нэг хэмжээгээр төлөвшсөн байна.
- Нийгэмд харш үзэл бодол, сэдэл зорилгодоо хөтлөгдсөн эрүүгийн хуульд заасан нийгэмд аюултай үйлдэл хийсэн байна гэсэн байдаг.

Гэмт хэрэгтэн бие хүн гэж хэдий үеэс тооцох тухай асуудал өдгөөг хүртэл маргаантай хэвээр байна. Үүнд, дараах хоёр төрлийн тайлбар байж болох юм.


Нэгдүгээрт. Гэмт хэрэгтэн бие хүн гэсэн ойлголт нь хууль зүйн талаасаа бол шүүхээс гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь тогтоогдсоноос хойш

Хоёрдугаарт. Гэмт хэрэгтэн бие хүн гэсэн ойлголт нь криминологийн хувьд гэмт хэрэг үйлдсэн үеэсээ тооцогдох нь зүйтэй.

Гэмт хэрэгтэн бие хүний талаарх тоон болон чанарын үзүүлэлтийг **гэмт хэрэгтэн бие хүний криминологи** шинж гэнэ. Гэмт хэрэг үйлдээгүй ч гэмт зан төлөв нь илрэн гарч буй гэмт бие хүний криминологи шинжийг үүнд хамруулан үзэж болно.

Гэмт хэрэгтэн бие хүний криминологи шинж:

- Нийгэм хүн ам зүйн шинж (нас, хүйс, боловсрол, гэр бүлийн байдал гэх мэт)
- Нийгмийн амьдралын янз бүрийн хүрээн дэх харилцаа холбоо, үүрэгтэй холбоотой шинж (сургууль хамт олноосоо хөндийрсөн, нийгэм болон өөрт ашигтай харилцаа нь суларсан, үл бүтэх хүмүүстэй нийлж дарвих, өөрийн гэсэн хүсэл эрмэлзэлгүй урсгалаар байх гэх мэт).
- Зан төлөв, сэтгэл зүйн шинж (ёс суртахуун, улс төрийн үзэл баримтлал, ертөнцийг үзэх үзэл бодол, итгэл үнэмшил, төсөөлөл, сэтгэхүйн үйл ажиллагаа, авир араншин гэх мэт) гэх мэт талаас нь авч үздэг.



Орчин үеийн сэтгэгчдээс Эрих Фром хүний мөн чанарыг нигүүлсэнгүй гэсэн боловч “Хүнд хүч хэрэглэн сүйтгэх боломж агуулагддаг” гээд хүний хүчирхийллийн хэв шинжийн тодорхой ангиллыг гаргасан. Үүнд:

- Хариу урвалын хүчирхийлэл
- Атаархал ба хардлагын хүчирхийлэл
- Өс хонзонгийн хүчирхийлэл
- Тэнцүүлэх хүчирхийлэл
- Садизм
- Цус урсгах ангийн хүсэл

Гэмт санаа бодол нь өөрөө аяндаа төлөвшин бий болохгүй, төлөвшсөн хүн бүр үргэлж байнга үйлдэхгүй бөгөөд хүний нийгэмд эзлэх байр суурь, үнэт зүйлсийн баримжаалал, нөхцөл байдал, тэдгээрийн харилцан үйлчлэлээс хамааралтай байдаг байна. Энэхүү төлөвшилд ерөнхий, сөрөг, байгалийн гэсэн нөлөөллийг авч үздэг.

Ерөнхий нөлөөлөл нь:	Сөрөг нөлөөлөл нь:	Байгалийн нөлөөлөл нь:
<ul style="list-style-type: none"> • Гарал угсаа • Хүмүүжил • Амьдрах орчин • Боловсрол • Мэргэжил • Нас хүйс • Биеийн хөгжил 	<ul style="list-style-type: none"> • Нийгэмд доогуур байр суурь эзлэх • Ядуу амьдрал • Ажилгүйдэл • Орон сууцны тааруу нөхцөл • Шилжилт хөдөлгөөн • Согтууруулах ундаа хэрэглэх • Сексийн замбараагүй байдал 	<ul style="list-style-type: none"> • Уур амьсгал (халуун, хүйтэн) • Жилийн улирал зэрэг болно.

Эдгээр нөлөөллийн үр дүнд бие хүн таван хэв шинж бүхий байдлаар төлөвшдөг ажээ.

Нэгдүгээр хэв шинж. Нийгэм тогтвортой, түүний тавьж байгаа шаардлага нэгэн хэвийн байгаа үед үг дуугүй хүлээн авагч “эвлэрэн зохицогч хүн”. Ийм хэв шинжийн хүн шинэ зүйлийг үг дуугүй ухамсарлахгүйгээр хүлээн авахыг эсэргүүцдэг бөгөөд ингэх нь хүний өвөрмөц чанар алдагдана гэж үздэг байна.

Хоёрдугаар хэв шинж. Сайн сайхан амьдрах, зорилгоо биелүүлэх уламжлалт арга замыг үгүйсгэгч ”шинээр бүтээгч хүн”. Энэ хэв шинжийн бие хүн аз сорих, хууль зөрчих, хүчээр түрэмгийлэх зэрэг ихэнхдээ шударга бус замаар эд баялагтай болохыг илүүд үздэг ажээ.

Гуравдугаар хэв шинж. Номхон хүлцэнгүй, энэ амьдралын жаргалыг үл тоогч, “өөр ертөнцөд тэмүүлэгч хүн”. Тэд хууль дүрэм, нийгмийн шаардлагыг ёс төдий мөрдөх бөгөөд өөрсдийн итгэдэг зан үйлдлийн хэм хэмжээ, заншил,



ёслол, ёс суртахууныг эрхэмлэн дээдэлдэг. Сайн тал нь нийгэмд давамгайлал бүхий зүйлийн эсрэг өөрсдийг ёс журмыг сөргүүлэн тавьдаггүй ажээ.

Дөрөвдүгээр хэв шинж. Нийгмийн зорилго, зорилт олонхийн хүлээн зөвшөөрдөг бүхнийг үгүйсгэн түүнээс зайлан холдож тусдаа амьдрагч “хөндийрөн тасрагч хүн”. Амиа егүүтгэх алхамд тун ойрхон амьдралыг сонгосон архаг архичин, мансуурагчид энэ хэв шинжийн хүмүүст хамаарагдана.

Тавдугаар хэв шинж. Уламжлалт хуучин бүхнийг солихыг эрмэлзэн, үргэлж шинэ арга замыг хайгч “идэвхтэй өөрчлөгч хүн”. Нийгмийн үнэт зүйлсийг үгүйсгэж, зорилгодоо хүрэх арга хэрэгсэл нь олонхтой зөрчилддөг энэ хэв шинжийн бие хүн нь улс, нийгэм, иргэдтэй огцом хурц мөргөлдөөнд олонтоо ордог ажээ.

Онолын хувьд Америкийн сэтгэл зүйч Абрахам Маслоу шинжлэх ухааны түвшинд гаргаж ирсэн сэдлийн хэмээх онолоос үүсэлтэй бөгөөд “хүний хэрэгцээгээ хангах шаардлага нь байгалийн хууль” гэсэн зарчимд тулгуурладаг. Ихэнх гэмт хэргийн шалтгаан нь хэрэгцээний дутагдал байх ба ердийн, олон нийтийн хүлээн зөвшөөрсөн арга хэрэгслээр хангах боломжгүй болмогц бусад арга замыг ашигладаг гэж үзэж болно. Жишээ нь, өлсөх, даарах, ичих, нэр төр нь гутаагдах гэх мэт.

Ер нь бие хүний хийсэн үйлдэл, алхам нь олон сэдлээс бүрдсэн бүхэл бүтэн хэрэгцээ, хүслийн үр дүн байдаг. Үүнийг ангилан авч үзье.

1. **Амьдралын амин чухал хэрэгцээ.** Энэ нь хүний амьд байхад зайлшгүй шаардлагатай зүйл юм.

- а) Биет оршихуйн хэрэгцээнд цангах ба өлсөхийг тайлах, дулаан байр, амрах унтах зэрэг багтана. Онцлог нь хүн эдгээр хэрэгцээгээ хангахын тулд юу ч хийхээс буцахгүй.
- б) Өөрийгөө хамгаалах хэрэгцээ бол амьдралын гол хуулийн нэг юм. Хүн амьд байх үедээ өөрийгөө хамгаалах чадвартай байхаас гадна ойр дотны хүмүүсийнхээ төлөө тэмцдэг. Хэрэв хүн өөрийн амь насанд нь аюул тулгарвал, зөн билиг мөн рефлексийн замаар хамгаалах үйлдэл хийдэг.
- в) Сексийнхэрэгцээ. Энэ бол өөрийн удамугсааны амьдралыг үргэлжлүүлэх гэсэн тэмүүлээс эхтэй биологийн хэрэгцээ юм. Бодит байдалд энэхүү хэрэгцээ дутагдсан үед янз бүрийн гэмт хэргийн бүрдлийг үүсгэх ба бүр үечилсэн цуст аллагын эхлэл болдог байна.
- г) Тусгаар тогтнох ба эрх чөлөөний хэрэгцээ нь амин чухал биш нийгмийн хүрээнд хамаарах юм шиг санагдаж болох ч амьд амьтны ертөнцөд зайлшгүй байдаг зөн билгийн мөн чанар юм. Эрх чөлөө, хамааралгүй байдал, хүний эрхэнд орохгүй байх, албадуулахгүй, ямар ч ичиж зовох зүйлгүй өөрийн дураар байх нь хүнд юугаар ч сольшгүй үнэт зүйл байдаг. Хэрэв хүн энэ байдлаа алдвал хавчигдмал нөхцөл байдлаас ангижрах, тэсвэрлэшгүй хамаарлаас чөлөөлөгдөх тэмүүлэл нь сэрдэг байна.

- д) Хөдөлгөөн үйлдэл хийх, биеийн болон сэтгэхүйн хүчийг зарцуулах хэрэгцээ. Биологийн хувьслын үр дүн нь хүнийг идэвхтэй ажиллагаа, тодорхой ачааллыг даах чадвартай болгосон боловч орчин үед амьдрахад үүнийг нэг их шаардахгүй болсон байна. Үүнтэй уялдан хүний бие махбодь биеийн болон сэтгэл хөдлөлийн хүчийг гаргах янз бүрийн боломж, гарц, арга замыг хайх болжээ.
- е) Таашаалын хэрэгцээ. Хүн зөвхөн амьдрахын төлөө тэмцэл хийхээс гадна өөрийн хэрэгцээг арвижуулан таашаал авахыг хүсдэг. Хэрэгцээг хангах үед эерэг сэтгэл хөдлөл их байх ба хүний мөн чанар нь таашаал авах, таашаагдахгүй зүйлээс ангижрах явдал гэж харагдана. Зарим хүмүүс хөдөлмөрлөхгүй, биеийн болон оюуны хүчээ зарцуулахгүй, хүчлэхгүйгээр таашаал хүртэхийн хүсдэг. Энэ нь тэднийг хулгайлах, хахууль авах, хуурах үйлдэл хийлгэхэд хүргэдэг.
2. **Материаллаг хэрэгцээ.** Биологийн амин чухал хэрэгцээнээс эхлэлтэй энэ хэлбэр нь өлсөхийг тайлах, дулаан орон сууц зэргээс бүрдэнэ. Хүн төрөлхтөн хөгжил дэвшлийг туулан өдгөөг хүрэхдээ амьд байлгах тэрхүү хэрэгцээ нь тав тухтай байдал, гоёмсог юмс, чанар гэх мэт үзэгдэл юмсаар баяжиж иржээ.
- Энэ нь сүүлдээ амин чухал хэрэгцээний түвшинд хүртлээ үнэлэгдэж, түүнд тэмүүлэх нь хэвийн гэсэн ойлголттой санал нийлэх болсон байна. Материаллаг хангамж руу чиглэсэн тэмүүлэл нь зарим төрлийн гэмт хэрэг рүү татан оруулж болох ба энэ нь хүн бүр хууль дүрэмд нийцсэн замаар хэрэгцээгээ хангах боломжгүй байдгаар тайлбарлагдана. Шунахай сэдэлтэй гэмт хэрэг нь үүний хамгийн тод жишээ болно.
3. **Нийгмийн хэрэгцээ.** Энэ нь хүн төрөлхтний соёл иргэншлийн хөгжлийн урт удаан хугацааны туршид нийгмийн холбоо харилцаа, социал бүлгүүдийн харилцан үйлчлэлийн дүнд төлөвшин тогтсон байдаг. Тиймээс нийгмийн хэрэгцээ нь хууль ёс, бусдын эрх эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг үйлдэл хийх шалтгаан болдог ч гэж үзэж болно.
- а) Ижил болох хэрэгцээ нь өөрийн ижил хүмүүстэй нэгдэж бусадтай нийтлэг байх мэдрэмж юм. Нөгөө талаас нийгмийн тодорхой бүлэгт харьяалагдах, түүний нэг хэсэг болох, тэнд ямар нэгэн байр эзлэх, бусдаас өөрийн ашиг тусыг мэдрэх, нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрөх байдлыг олж авах, хүндлэгдэх хэрэгцээ юм. Харамсалтай нь энэ ертөнцөд дасан зохицох эрмэлзэл, тусгаарлагдах байдлаас ангижрах, ганцаардмал байдлаас салах нь тийм ч амар зүйл биш агаад ялангуяа, өсвөр насныхны дунд энэхүү үзэгдэл нь хүч хэрэглэх, түрэмгийлэх, цэрэг дайны урлаг эзэмших зорилго бүхий нэгдэл үүсэх үндэслэл болж гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг бүрдүүлж байна.



- б) Өөрийгөө идэвхжүүлэх хэрэгцээ. Энэ бол хүн байгаа гэдгээ батлах, илэрхийлэх, сорих, үзүүлэх тэмүүлэл юм. Илрэх хэлбэр нь боловсрол, мэргэжил, ажил, нийгмийн байр суурь, гэр бүл, хүүхдийн хүмүүжил зэрэг байх ба энэ хэрэгцээ нь хангагдахгүй бол хүний хувийн чанарыг устгах, арилгах нөлөө үзүүлдэг. Гомдол, хорсол, бүтэлгүй амьдралын эмзэглэл нь хүнийг жирийн хүмүүсээс бүрмөсөн тасрахад хүргэнэ. Хэрэв түүнд байгалиас заяасан шавхагдашгүй хүч, юунд ч торохгүй хүсэл эрмэлзэл байгаа бол түүнийгээ гэмт хэргийн ертөнцөд харуулна, тиймгүй бол амиа егүүтгэх байдлаар ихэвчлэн төгсдөг байна.
- в) Нийгэмд өндөр байр суурьтай байх хэрэгцээ ч ололт амжилт, хүндлэгдэх, нэр хүндтэй болох, бусдаас илүү байх мэдрэмж гэж ойлгож болно. Гэвч энэ хэрэгцээгээ хангах нь тухайн хүнээс ихээхэн хүч хөдөлмөр, чармайлт, эр зориг, зорилгодоо хүрэх цэгцтэй бодлого, зарчимтай байхыг юуны түрүүнд шаардана. Чадварлаг бус хүмүүс амжилт руу тэмүүлэх, хоосон их зан гаргах, алдар нэрд дурлах зэрэг нь гэмт хэрэгтэн болох магадлалыг ихэсгэдэг. Эндээс л хуурах, хуурамчаар үйлдэх, хууль бус аргаар гартаа оруулах, бусдын нээлт шинэ бүтээлийг өөрийн болгох үйлдлүүд гарч ирдэг байна.

Ийнхүү бидний дунд амьдарч буй мөртлөө үнэт зүйлийн баримжаалал өөр, хямралд хандах хандлага ондоо, бусадтай адил байж чаддаггүй гэмт хэрэгтэн гэгч бодгалийг эрдэмтэн судлаачид олон талаас нь судлан үзэж өөр өөрийн онол, үзэл баримтлал, таамаглал тайлбарыг гаргасан байдаг. Гэхдээ зорилгын хувьд нэгдмэл байр суурьтай байдгийг дурьдах зүйтэй.

Энэ нь гэмт хэрэгтний онцлог шинжийг харуулахыг хичээсэн, тэдний хийсэн үйлдэлд нь тохирсон ял шийтгэл оногдуулахад тусалсан шинжтэй, гэмт явдал гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын ерөнхий чиглэлийг тогтооход чиглэгддэг зэргээс харагдана.

ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Гэмт бие хүний ойлголт, судлахын ач холбогдол?
2. Гэмт санаа бодол төлөвших талаарх онол, үзэл баримтлалуудын талаар?
3. Гэмт хэрэгтэн бие хүн төлөвших нь гэмт санаа бодлоо хэрэгжүүлэхэд нөлөөлөх гадны хүчин зүйлс тэдгээрийн онцлог.
4. Гэмт хэрэгтэн бие хүний криминологи шинжийн тухай
5. Гэмт хэрэгтэн бие хүний ангилахын ач холбогдол?
6. Гэмт бие хүн, гэмт хэрэгтэн бие хүний хоорондын ялгааг тодорхойлно уу.

СЭДЭВ 6. ГЭМТ ЯВДЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛЛАГАА СУДЛАЛ

Сэдвийн зорилго: *Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажиллагааны талаар тэдлэг олох, нийгмийн сөрөг үзэгдлээс урьдчилан сэргийлэх ажиллагааг зөв, оновчтой авч хэрэгжүүлэх, гэмт явдлыг хяналтад байлгах тэдгээрийн үр дүнг тодорхойлох, үнэлэх, дүгнэх чадвар эзэмших, хяналт, урьдчилан сэргийлэлтийг шинжлэх ухааны тогтоосон зарчмын дагуу хэрэгжүүлэх хандлага тогтох.*

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажиллагааны ойлголт, зорилт

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажиллагаа гэдэг нь гэмт явдлын онцлог, түүний хор уршиг, шалтгаан нөхцөл, хохирогч, гэмт бие хүн, тэдгээрийн онцлог, төлөвшин тогтох зүй тогтол, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, түүний нийгэмд болон гэмт явдалд нөлөөлж буй байдал, үр дүнг судалсны үндсэн дээр гэмт явдлыг бууруулах, саармагжуулах, тогтворжуулах, таслан зогсоох, устгахад чиглэгдсэн нийгэм эдийн засаг, улс төр, хууль эрх зүйн цогц үйл ажиллагаа.

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажиллагааны зорилт нь:

1. **Гэмт явдлын гаралтыг бууруулах**-Гэмт хэргийн гаралтыг урьд байсан тоон болон чанарын үзүүлэлтийг багасгахад чиглэсэн арга хэмжээ
2. **Гэмт явдлыг саармагжуулах**-Гэмт хэргийн тоон үзүүлэлтийг бууруулж чадахгүй ч нийгэмд болон бусдад учруулж буй хор уршгийг урьд байснаас тодорхой хэмжээгээр багасгахад чиглэгдсэн арга хэмжээ
3. **Гэмт явдлыг тогтворжуулах**- Гэмт хэргийн гаралт болон учруулах хор уршгийг тодорхой хугацаагаар нэгэн хэмээр барьж байхад чиглэгдсэн арга хэмжээ
4. **Гэмт явдлыг таслан зогсоох**-Тодорхой төрлийн буюу онцлог үйлдэлтэй гэмт хэргийг завдалт болон үйлдэгдээд эхэлсэн хойно нь буюу үйлдэгдэхээс өмнө тасалдуулахад чиглэгдсэн арга хэмжээ, түүнчлэн хэсэг хугацаагаар гэмт хэрэг үйлдэгдэх боломжийг хаахад чиглэгдсэн арга хэмжээ багтана.

Дээрх зорилтыг хангахад ямарваа байгууллага дангаараа буюу тодорхой нэг үйл явц, үзэгдэлтэй тэмцэх нь хүссэн үр дүнд хүрэхгүй. Тиймээс гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь шаталсан, цогцолбор арга хэмжээ юм.



Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний төрөл

Түвшингээр	Цар хүрээгээр нь	Шинж чанараар нь
<ul style="list-style-type: none"> • Ерөнхий • Тусгай • Нэгбүрчилсэн 	<ul style="list-style-type: none"> • Нийт нутаг дэвсгэрийн хэмжээний • Тодорхой засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн • Нийгмийн тодорхой бүлгийн • Нийгэмд харш этгээд зантай нь тогтоогдсон хүмүүст чиглэгдсэн • Гэмт хэрэг үйлдсэн тодорхой нэг этгээдрүү чиглэсэн нэг бүрчилсэн арга хэмжээ. Нэг бүрчилсэн тодорхой нэг шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэгдэнэ. 	<ul style="list-style-type: none"> • Аж ахуй, эдийн засгийн (эдийн засгийн нөхцөл байдлыг дээшлүүлэх, сайжруулах) • Нийгэм улс төрийн (төрийн тогтвортой байдлыг хангах, нийгмийн харилцааг улам хөгжүүлэх) • Үзэл суртлын (зөв төлөвшилтэй болгох, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх) • Соёл хүмүүжлийн • Удирдлага зохион байгуулалтын (төр олон нийтийн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох) • Техникийн (ШУ, технологийн ололтыг нэвтрүүлэх) • Эрх зүйн (хуулийг цаасан дээр бичигдсэн үгс биш амьдрал дээр хэрэгжих бодит үр дүн болгох, түүнийг нийгэмтэйгээ уялдан зохицсон зохицуулах чадвар сайтай, хэрэгжүүлэгч субъектүүд нь хэлбэрэлтгүй сахидаг байх)

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажиллагааны үндсэн зарчим:

- Судалгаа шинжилгээнд суурилсан, үндэслэлтэй байх;
- Тухайн нутаг дэвсгэрийн гэмт явдлын онцлогт тохирсон;
- Урьдчилан сэргийлэх ажиллагаа төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;
- Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажиллагааг тодорхой цаг хугацааны давтамжтай, тасралтгүй явуулах;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг цогц байдлаар нь авч хэрэгжүүлэх;
- Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажиллагааны үр дүнг тогтоосон хугацаанд тооцож байх;
- Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажиллагаанд иргэд, байгууллага, олон нийтийн оролцоог хангах.

Урьдчилан сэргийлэх ажиллагааг дараах 4 хэсэгт ангилан үзэж болно.

Нэг. Эртнээс урьдчилан сэргийлэх.

Хоёр. Хүмүүжил зан төрхийн хувьд эвдэрч, бага хэмжээгээр эрхийн зөрчил гаргасан хүмүүсийг гэмт хэргийн замд орохоос нь өмнө урьдчилан сэргийлэх.

Гурав. Гэмт хэрэгт сэжиглэгдэж буй хүмүүст хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх.

Дөрөв. Гэмт хэрэгтэн бие хүн давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх.

ХЯНАЛТЫН АСУУЛТ:


- Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний ойлголт?
- Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний зорилго, зорилт?
- Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний төрөл, ангилалт?
- Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажиллагааны зарчим?
- Хүчин төгөлдөр хууль тогтоомж судлан гэмт явдлаас урьдчилан сэргийлэх субъектүүд тэдгээрийн нийтлэг эрх үүргийг тодорхойлно уу.



СЭДЭВ 7. КРИМИНОЛОГИЙН СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Сэдвийн зорилго: *Криминологийн судалгааны аргачлал боловсруулах ур чадвар төлөвшүүлнэ.*

Ниймийг ямар сөрөг үзэгдэл, үйл явц, гэмт болон хохирогч бие хүнийг судалж байгаагаас криминологийн судалгааны арга, арга зүй, аргачлал өөр өөр байдаг.



Суурь судалгаа нь ихэвчлэн нээх, тайлбарлах, танилцуулах чиглэлтэй байдаг боловч ихэнх тохиолдолд шинэ зүй тогтлыг нээхэд анхаардаг тул судалгааны үр дүнг практикт шууд нэвтрүүлэх зорилгыг агуулдаггүй.

Суурь судалгааны үр дүн нь гэмт явдалтай тэмцэх стратеги, бодлого боловсруулахад ашиглагддаг.

Хавсарга судалгааг тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд буюу нэг төрлийн гэмт хэргийг харьцангуй явцуу хүрээгээр судлан үр дүнг богино хугацаанд хэрэгжих үйл ажиллагаанд ашиглах боломжтой.

Криминологийн судалгааг зорилгоор нь:

- **нээх** (асуудлыг шинээр дэвшүүлж, шинэ үр дүнд хүрэх үйл ажиллагаа),
- **тодорхойлох** (асуудлын хариултыг олж, юмс, үзэгдлийн өөрчлөлтийн мөн чанарыг бодитой, үнэн зөв тодруулах үйл ажиллагааг тодорхойлох судалгаа),
- **тайлбарлах** (асуудлын шалтгаан, үр дагаврыг олж тогтоох үйл ажиллагааг) гэж хуваана.

Криминологийн судлах зүйлийн онцлог, зүй тогтол, бусад шаардлагатай мэдээллийг цуглуулах, боловсруулах, нэгтгэн дүгнэж, дүн шинжилгээ хийх тодорхой арга хэрэгслийн цогцыг **криминологийн судалгааны арга зүй** гэнэ.

Криминологийн судалгааны ач холбогдол:

- Гэмт явдалтай хийх тэмцлийг улс төрөөс ангид байлгана,
- Гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлогыг оновчтой тодорхойлж, хүч хэрэгслээ зөв хуваарилах боломжтой болно,
- Нийгмийн сөрөг үзэгдлийг хэмжих боломжтой болно,
- Гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны явц, үр дүнг тодорхойлох боломжтой болно.

Криминологийн судалгааны түгээмэл арга

Криминологийн судлах зүйлийг танин мэдэх тодорхой үйл явцын бүх үе шат болон аливаа шинжлэх ухааны салбарын судалгааны явцад эрдэмтэн, судлаачдын удирдлага болгодог горим журам нь түгээмэл арга юм. Энэ аргын хамгийн анхдагч жишээ буюу хамгийн эртнийх нь диалектик, метафизик арга. Цаашилбал түгээмэл аргын хүрээнд: задлан шинжлэх (анализ), зөн совин (интуици), өвөрмөц үзэгдлийг судлах (феноменологи), хийсвэрлэх аргууд, тайлбарлах, ойлгох (герменевтик), бүтэцлэх, хуурмаглах (фальсификаци), олончлох (плюралист), нэгтгэх (интегратив), хэрэглээ, ашиглах (прагматив), жишин харьцуулах (компаратив) аргуудыг багтааж болно. Арга нь шинэ мэдлэг, онолыг бүтээхийн тулд хэрэглэдэг учир ямар ч мэдлэг нэг талаас шинжлэх ухааны танин мэдэхүйн үр дүн, нөгөө талаас шинэ мэдлэгт хүрэх хэрэгсэл болдог.

Криминологийн судалгааны тусгай арга

Гэмт явдлын онцлог шинжээс хамааран криминологийн судалгааны тусгай арга бий болдог. Тухайлбал, хүүхдийн гэмт явдлыг судалж байсан арга, аргачлалаар авлигыг судлах нь үр дүн муутай. Архидан согтуурах үзэгдлийг янхандалт судалж байсан аргаар судалж болохгүй.

Гэмт явдал нь түүхэн цаг хугацаа, нутаг орон, хүмүүсийн үнэт зүйл, зан заншлын онцлогоос хамааран өөрчлөгдөж байдаг онцлогоос хамааран арга, аргачлал өөрчлөгдөж байдаг. Тухайлбал, 1970 онд үйлдэгдэж байсан хулгайлах гэмт хэргийг судалж байсан аргаар энэ цагт үйлдэгдэж буй хулгайлах гэмт хэргийг судлах нь төдийлөн зохимжтой бус. АНУ дах хүүхдийн гэмт явдлыг судалж байсан арга, аргачлалыг хуулбарлан Монгол Улс дах хүүхдийн гэмт явдлыг судлах нь шууд үр дүнгээ өгөхгүй.

Криминологийн судалгаа хийхэд судлаачаас доод тал нь хоёр шинжлэх ухааны салбарын мэдлэг шаарддаг. Тухайлбал, насанд хүрээгүй хүмүүсийн дунд криминологи судалгаа явуулахад ихэвчлэн хос мэргэжил, боловсролтой хүн явуулах нь илүү үр дүнтэй байдаг (тухайлбал, сурган хүмүүжүүлэгч-хуульч, сэтгэл судлаач- хуульч гэх мэт).



Дээр дурдсан гурван нөхцөлөөс харахад криминологийн судалгааны тусгай аргыг тогтмон хэвшмэл гэж ойлгож болохгүй.

Криминологийн судлах зүйлийг судлахад зориулан боловсруулагдсан цогц арга, аргачлалыг криминологийн судалгааны тусгай арга гэнэ.

Криминологийн судалгааны тусгай арга, аргачлал боловсруулахад дараах нийтлэг аргуудыг ашигладаг:

- Социологи
- Статистик
- Математик
- Хууль зүйн гэх мэт.

Криминологийн судалгааны аргачлал боловсруулах үе шат


1. Тухайн судлах зүйлийн цар хүрээ, зорилго, зорилт, хамрах хүрээгээ тодорхойлох (шаардлагатай бол нөөц, хүч, боломжийг тодорхойлох)
2. Тухайн судлах зүйлийг гадаад, дотоодод судалж байсан судалгааны арга, аргачлалыг судлан ололт, дутагдалд дүн шинжилгээ хийнэ.
3. Тухайн судлах зүйлийг судлахад ямар ямар шинжлэх ухааны арга, аргачлал ашиглагдаж болохыг тодорхойлох.
4. Шаардлагатай салбарын эрдэмтэн судлаачдын баг эсхүл шүүмжлэгчдийн баг бүрдүүлэх,
5. Шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох
6. Тоон болон чанарыг үзүүлэлтийг харьцуулагдахуйц хэлбэрт оруулах (тоон хэлбэрт оруулах, түүний утгыг тодорхойлох, томъёо боловсруулах)
7. Судалгаанд ашиглагдах нэр томъёог нэг мөр болгох
8. Судалгаанд шаардагдах мэдээллийг эх үүсвэрээ тодорхойлох
9. Мэдээлэл цуглуулах аргачлалаа боловсруулах
10. Боловсруулсан аргачлалаа туршиж, хэлэлцүүлэх
11. Аргачлалаа баталгаажуулах

ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. “Хэмжихгүйгээр хийж чадахгүй” гэдэг үгний утгыг тайлбарлана уу.
2. Багшийн өгсөн өгөгдлийн дагуу тодорхой гэмт хэргийг судлах Криминологийн судалгааны аргачлал боловсруулна уу.

СЭДЭВ 8. КРИМИНОЛОГИЙН ПРОГНОЗ, ТӨЛӨВЛӨЛТ

Сэдвийн зорилго: *Криминологийн судалгааны үр дүнг ашиглан прогноз хийх, прогнозод тулгуурлангэмт явдалтай тэмцэх бодлого, стратеги, төлөвлөгөө боловсруулах ур чадвар төлөвшүүлэх*



Криминологийн прогноз гэдэг нь криминологийн шинжлэх ухааны хөгжлийн хандлага эсхүл гэмт явдлын ирээдүйн байдал, түүний шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх боломж, гэмт явдалд болон гэмт хэрэгтэн бие хүн төлөвшихөд нөлөөлж болох бусад байдлыг шинжлэх ухааны үүднээс судлан дүгнэж, эргэцүүлсэн магадлал юм.

Криминологийн прогнозын ерөнхий зорилго нь гэмт явдлын ирээдүйн хандлагыг тодорхойлох ерөнхий үзүүлэлтүүдийг тогтоох, үүний үндсэн дээр энэ зохисгүй үзэгдэлд нөлөөлөх урьчилан сэргийлэх арга замыг эрж олоход оршдог.

Криминологийн прогнозын зорилт:

- Гэмт явдлын ирээдүйн хандлага (бүтэц, түвшин, хөдөлгөөн) өөрчлөлтүүдийг тодорхойлох;
- Цаашид шинээр бий болох, устаж алга болж болох тодорхой гэмт хэрэг, нийгмийн хор аюул нь ихсэх гэмт хэргийг тодорхойлох;
- Гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого боловсруулахад ач холбогдол бүхий бүх нөхцөл байдлыг тодорхойлоход ашиглах;
- Хууль сахиулах байгууллагаас гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах, идэвхжүүлэх, ерөнхий үзэл баримтлал боловсруулахад ашиглах.



Криминологийн прогнозын ач холбогдол

- Гэмт явдалтай хийх тэмцлийг үе шаттай зохион байгуулах;
- Гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийг тогтоох;
- Гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх байгууллагын бүтцийг бий болгох, боловсон хүчнийг бэлтгэх.

Криминологийн прогнозын нийтлэг арга		
Экстраполяцийн арга Үзэгдэл, үйл явцын өнгөрсөн, өнөөгийн байдлаар ирээдүйн хандлагыг тодорхойлох арга	Загварчлах арга боловсруулах объектийн онцлог тал, шинж чанарыг хялбарчилж, математик хэллэгээр харуулах арга	Шинжээчийн дүгнэлтийг үнэлэх арга Үзэгдэл, үйл явцын талаар дадлага туршлагатай ажилтан, мэргэжилтэн, судлаач нарын санал, судалгаа шинжилгээний ажлын үр дүнд тулгуурлах арга

Криминологийн прогноз боловсруулах үе шаттай цаг хугацаа шаардсан ажлын үр дүн нь товчхоноор дараах байдлаар томъёолж болно. Тухайлбал:


- гэмт явдал өснө,
- гэмт явдал буурна,
- гэмт явдал хэвээр байна,
- тогтворгүй байна.

Мөн түүнчлэн энэ хугацаанд:

- гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажиллагааны явц саарна;
- гэмт явдлаас урьдчилан ажиллагааны явц эрчимжинэ гэх мэт

Криминологийн төлөвлөлт

Криминологийн төлөвлөлт гэдэг нь гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн тодорхой зорилго, зорилт, тодорхой арга хэмжээ, хүрэх үр дүнгийн цогц юм.



Криминологийн төлөвлөгөө боловсруулахад баримтлах зарчим:

- хууль ёсны зарчим,
- иж бүрэн цогц байх,
- иргэд, байгууллага, иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах,
- үндэслэлтэй байх,
- үр ашигтай байх,
- тодорхой байх,
- хэмжигдэхүйц байх,
- үр дүн тооцож байх.

Криминологийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх газар нутгаар, хамрагдах хүрээгээр, цаг хугацаагаар тус тус боловсруулдаг.

ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Криминологийн прогнозын ойлголт, зорилго, ач холбогдол?
2. Криминологийн прогноз боловсруулахад шаардагдах зүйлс?
3. Криминологийн төлөвлөлтийн ойлголт, зорилго, ач холбогдол?
4. Криминологийн прогноз, төлөвлөлтийн хоорондын уялдаа холбоо?
5. Криминологи төлөвлөгөө, түүнийг боловсруулах ажлын ойлголт?
6. Криминологийн төлөвлөгөөний бүтэц, агуулга?



ТУСГАЙ АНГИ

ТАЙЛБАР: Хуулийн сургуулийн сургалтын онцлогоос хамааран Криминологийн тусгай ангийн сэдэв нь өөрчлөгдөх эсхүл бие даасан хичээл болон задардаг. Криминологийн тусгай ангид тусгагдсан мэдээлэл нь судлаачийн онцлог, хэрэглэж буй арга зүй, аргачлалаас хамааран өөр өөр байдаг. Түүнчлэн тусгай ангид ашиглагдсан мэдээлэл, дурдсан нөхцөл байдал нь цаг хугацааны явцад өөрчлөгддөг тул 4 жил дотор бичигдсэн нэг сэдэвт бүтээл, судалгаа шинжилгээний ажлын тайлан, эрдэм шинжилгээний илтгэлтэй танилцаж нэмэлт хийж байхыг та бүхнээс зохиолчдын баг хүсч байна.

Ийтээс тусгай ангийн сэдвийг гурван зохиогчийн боловсруулснаар тусгав.

СЭДЭВ 9. ХҮЧ ХЭРЭГЛЭСЭН ГЭМТ ЯВДАЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

Сэдвийн зорилго: *Хүч хэрэглэсэн гэмт явдлын криминологи шинж, хор уршиг, шалтгаан нөхцөл, тусгай шинжийг судлаж, энэ төрлийн гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах чадвар эзтших.*

Бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг тодорхой сэдэл зорилгын үүднээс (шунахай, танхай, өс хонзон, захиалгаар гэх мэт) бие махбодь, сэтгэл зүй, эрх мэдэл зэргийн давуу байдлаа илтээр ашиглан зөрчих гэмт хэрэг, зөрчлийн нийлбэр цогцыг хүч хэрэглэсэн гэмт явдал гэж ойлгож болно.

“Хүч хэрэглэсэн хүнд гэмт хэрэг гэсэн ойлголтод бие хүний амь нас, эрүүл мэнд, бие махбодь, бэлгийн халдашгүй байдлын эсрэг чиглэсэн нийгмийн хор аюулаар ихтэй, тодорхой бүлэг хэргүүд хамаардаг. Тухайлбал, бусдыг санаатай алах, бусдын бие махбодид санаатай хүнд гэмтэл учруулах, танхайрах, хүчиндэх гэмт хэргүүд хамаарна.” гэжээ.

Хүч хэрэглэсэн хүнд гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах, түүнээс урьдчилан сэргийлэх асуудал хэзээнээс криминологийн шинжлэх ухааны болон хууль сахиулах байгууллагын чухал зорилт болж ирсэн. Учир нь дээрх гэмт хэргийн гаралт жил ирэх тусам өсөх хандлагатайн дээр нийгмийн хор аюулын хэмжээ нэмэгдэж байгаа болно. Үүний зэрэгцээ энэ төрлийн гэмт хэргийг бүлэглэж үйлдэх, рецидив гэмт хэрэгтнүүд үйлдэх, хүндрүүлэх шалтгаантай мөн согтуугаар үйлдэх явдал нэмэгдэж байгаа нь ихээхэн сэтгэл түгшээж байгаа юм.

Хүн амины болон хүч хэрэглэсэн гэмт хэргүүдийн ихэнх нь хот суурин газруудад үйлдэгдэж байна. Ялангуяа, иргэдийн орон байр, оршин суугаа газруудад үйлдэгдэх нь илүү олон байна. Судалгаанаас үзэхэд энэ төрлийн гэмт хэрэг хавар, зуны улиралд ихэвчлэн үйлдэгддэгээс гадна 50-иас илүү хувь нь долоо хоногийн баасан, бямба, ням гаригт, 18-22 цагийн хооронд олонтаа бүртгэгдэж байгаа юм.

Хүн амьны гэмт хэрэг, хүний эрүүл мэндэд хүнд гэмтэл учруулсан гэмт хэргийн хувьд зарим онцлог ялгаа байдаг. Тухайлбал, Хүний эрүүл мэндэд хүнд гэмтэл учруулсан гэмт хэрэг нь:

- Хот суурин газар үйлдэгдэх илүү магадлалтай,
- Бүлэглэн үйлдэгдэх нь хүн амины гэмт хэрэгтэй харьцуулахад харьцангуй цөөн,
- Хохирогчдын дунд үл таних хүн харьцангуй олон байдаг.

Энэ төрлийн гэмт хэргийн дотроос криминологи шинж чанарын хувьд нилээн өвөрмөц гэмт хэрэг бол хүчингийн гэмт хэрэг юм. Үүнд:

1. Нуугдмал байх магадлал өндөр;
2. Энэ гэмт хэргийг үйлдэх үед хохирогчийг алахаар заналхийлэх явдал цөөнгүй гардаг;
3. Бүлэглэж үйлдэх магадлал өндөр;
4. Сэтгэхүйн хүч хэрэглэх явдал түгээмэл.

Танхайрах гэмт хэрэг хүч хэрэглэсэн гэмт хэргийн дотор тоогоороо ч, нийгмийн аюулаараа ч дээгүүр байр эзэлдэг. Нөгөөтэйгүүр хүн амины, дээрэм, хүчингийн гэмт хэргийн эхлэл болдгоороо онцлогтой. Энэ гэмт хэрэг олон нийтийн газар, кино теарт, үзвэр үйлчилгээ, цэнгэлдэх хүрээлэн, гуанз ресторан, дэлгүүр мухлаг, ваг зэрэгт ихэвчлэн гардгаас гадна, хагас бүтэн сайн өдөр, баяр ёслолын үеэр, цалин буух үеэр голдуу үйлдэгдэж байна. Мөн танхайн гэмт хэрэг үйлдэгчдийн дийлэнх нь боловсрол багатай, сургууль завсардсан эсвэл сурлагаар тэнцээгүй хасагдсан, ажил хөдөлмөр эрхэлдэггүй хүмүүс, ажил сургуультай боловч нийгмийн идэвх, сонирхол муутай, соёл хүмүүжил олон нийтийн ажилд оролцдоггүй, сонин хэвлэл, ном унших нь бага, чөлөөт цагаа дэмий сэлгүүцэх, архидан согтуурах зэргээр өнгөрүүлдэг хүмүүс байдаг байна.

Хүч хэрэглэсэн гэмт явдлын хор уршиг:

1. Нийгэмд айдас бий болгоно.
2. Нийгмийг хамарсан эмх замбараагүй байдал бий болох урдач нөхцөл болдог.
3. Хүүхэд, залуучуудыг гэмт үйлдэлд татан оруулдаг.
4. Зохион байгуулалттай гэмт явдал хүчирхэгжих хөрс суурь болдог.



Хүч хэрэглэсэн гэмт явдлын шалтгаан, нөхцөл

Энэхүү гэмт хэргийн шалтгаан нь гэмт явдлын шалтгааны үндсэн шинжийг тодорхойлдог гэж үзэж болно. Сүүлийн жилүүдэд манай улс эдийн засаг, нийгэм, улс төрийн гүнзгий хямралд байсны улмаас нийгмийн амьдралд янз бүрийн зөрчил гүнзгийрч ирсэн. Ийм байдал нь хүмүүсийн амьдралд янз бүрийн дарамт шахалт үзүүлэх, уламжлалт зан заншил алдагдах, хууль биелүүлэх сэтгэл зүйг үгүйсгэх, эрх зүйн ухамсрыг доройтуулах зэрэг үр дагаврыг бий болгосон юм. Хүмүүсийн амьжиргааны баталгаа алдагдах, бодит орлого буурах, ядуучуудын нийгэмд эзлэх жин огцом өсөх, ажилгүйдэл газар авах, шашны олон урсгал гарч ирэх, инфляци нэмэгдэх, үйлдвэрлэл унах, хээл хахууль түгээмэл үзэгдэл болох гэх мэт гэмт хэргийн нөхцөл байдалд, тэр дундаа хүч хэрэглэсэн гэмт хэргийн гаралтад шууд нөлөөлдөг байна. Тухайлбал, эд материалын болон амьдралын таагүй нөхцөл байдлын улмаас бие хүний ирээдүйдээ итгэх итгэл нь алдагдах, харгис хэрцгий зантай болж, “би яасан ч яадаг юм” гэсэн санаа бодолтой болох

- Гэмт хэргийн тухай байнга сонсох, түүний нөлөөн дор үйл ажиллагаа, чөлөөт цагаа өнгөрөөх нөхцөл байдал;
- Хохирогчийн гэм буруутай зан төлөв, харилцаа жишээ нь, хохирогч эхэлж өдөх, үг хэлээр доромжлох, ёс суртахуунгүй авирлах гэх мэт;
- Танхай балмад, хорлон сүйтгэх үзэл бодолтой, тодорхой хүмүүсийн бүлэглэл бий болох, нөхцөл бүрдсэн тохиолдлыг ажиглаж улмаар захиалгаар хийх;
- Нийгмийн хэв журам зөрчигчид, жижгээр танхайрагчид, архидан согтуурагчдад хууль зөрчсөн үйлдэлд нь хариуцлага хүлээлгэхгүй байх, өөгшүүлэх, эсвэл тийм үйлдлийг хууль сахиулах байгууллага мэдэлгүй удаан хугацаанд нуугдмал байлгах зэрэг нь энэ төрлийн ноцтой гэмт хэрэг үйлдэгдэхэд бэлтгэл болдог;
- Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны дутагдал, үндэслэлгүйгээр ялаас чөлөөлөх, ялаас хугацаанаас нь өмнө хууль бусаар суллах, гэмт хэргийг түргэн шуурхай, хугацаанд нь илрүүлэхгүй байх;
- Галт зэвсгийг хууль бусаар хадгалах, худалдах, бусдад дамжуулах.

Догшин хэрцгий, хүчирхийлэх зан төлөв, хүүхэд ахуй насандаа бүрэлдсэн нь энэ гэмт хэргийн шалтгаан болдог. Үүнд :

1. Гэр бүлийн ахуй нөхцөл, аливаа асуудлыг хүчирхийллийн аргаар шийддэг буруу хэвшил, ойр дотны хүнтэйгээ харгис хэрцгий ханддаг арга барил хүүхдийн хэв шинж болон тогтох;
2. Оршин суугаа газар, ажил сургуулийн хамт олны доторх хүмүүсийн харилцаанд байдаг бие биенээ дээрэлхэх харилцаа, мал амьтанд хатуу ширүүн харьцаж байгаа байдал;

3. Хүүхэд залуучуудын архи болон мансууруулах бодис хэрэглэх үйл ажиллагаанд татан оруулах гэх мэт нөхцөл байдлыг тоочиж болно.

Хүч хэрэглэсэн гэмт хэргийн үед учирсан сэтгэл санааны хохирол нь бусад гэмт хэргийг бодвол илүү хүнд, урт удаан хугацаанд үргэлжилдэг сөрөг талтай. Иймээс түүний шалтгаан нөхцөлийг нарийн нягт илрүүлэн гаргаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг нухацтай бодож боловсруулах нь зүйтэй. Зарим эрдэмтэд үүний тулд зарим нэг ангилалт хийхийг оролдсон байдаг. Жишээ нь:

- Улс төрийн,
- Шунахайн,
- Амиа бодох,
- Хөнгөн хийсвэр, томоогүй,
- Хулчгар байдал.

Хүч хэрэглэсэн гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга зам

Криминологид гэмт явдал, гэмт хэрэгтэй тэмцэхэд өргөн ашигладаг ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн арга хэмжээг хүч хэрэглэсэн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд ашигладаг. Хамгийн гол нь хүнийг энэрэнгүй үзлээр хүмүүжүүлэх, ёс суртахууны хувьд хүмүүнлэг мэдрэмжтэй байх, хууль ёс заншлаа зөрчихийг үл тэвчихэд сургах нь энэ тэмцлийн зорилго байх ёстой.

Хүч хэрэглэсэн гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн чиглэл дараах нөхцөлөөс бүрдэж болно. Үүнд :

- Архидан согтуурах явдалтай хийх тэмцлийг төрийн бодлогын түвшинд тавих;
- Мансууруулах бодис хэрэглэх, худалдаалах, тараах боломж нөхцөлийг хаах;
- Гэр бүлийн болон ахуйн зөрчлөөс үүссэн хэрэг маргааныг цаг тухайд нь зохицуулах, таслан зогсоох;
- Олон нийтийн хэв журмыг гудамж, талбай, нийтийн үйлчилгээний газруудад чанд сахиулах;
- Үндэсний болон нутгархах үүднээс үүссэн зөрчлийг цаг тухайд нь арилгах;
- Рецидив болон мэргэжлийн гэмт хэрэгтнүүдээс насанд хүрээгүй хүмүүст нөлөөлөх нөлөөллийг таслан зогсоох;
- Насанд хүрээгүй хүмүүс гэр оронгүй траншейн, хонгилоор амьдрах нөхцөлийг арилгах;
- Гэмт хэрэг үйлдэж болзошгүй залуучуудын бүлэглэлийг илрүүлж, үйл ажилгаанд нь хяналт тавих, тараах;
- Гэмт хэрэг үйлдэхийн тулд эвсэн нэгдсэн, холбоо тогтоосон гэмт бүлэглэлүүдийг илрүүлэх ажлыг идэвхжүүлэх;



- Халуун, хүйтэн зэвсгийг хууль бусаар хадгалах, борлуулах, үйлдвэрлэх ажиллагааг цаг алдалгүй илрүүлэх;
- Хүчирхийлэх, танхай балмад авирлах үйл ажиллагааг жигшүүлсэн ухуулга, сурталчилгааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр системтэй явуулах;
- Бусдын амь насанд халдах, хүнд гэмтэл учруулахдаа хийсэн заналхийлэл нь биелэгдэх үндэслэлтэй бол таслан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Хүч хэрэглэсэн гэмт хэрэг үйлдсэн хүмүүст оногдуулах ял шийтгэлийг хууль зүйн дагуу шудрага оногдуулах гэх мэт.

Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хүн амын тодорхой бүлгүүдийн дотор зохиох урьдчилан сэргийлэх арга хэмжээ онцгой нөлөөтэй гэж үзэж болно. Тухайлбал, насанд хүрээгүй хүмүүс ба залуучууд, согтууруулах ундаа хэрэглэгчид, сэтгэл мэдрэлийн эмчилгээ хийлгэж буй хүмүүс, ажил сургуульгүй хүмүүс, урьд өмнө гэмт хэрэгт шийтгүүлж байсан хүмүүсийн дунд зохиох ажлуудыг хамааруулан үзэж болно. Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тодорхой хүнийг гэмт хэрэг, зөрчилд оруулахгүй байхын тулд зохиодог нэг бүрчилсэн арга хэмжээ чухал байр эзэлдэг. Хүч хэрэглэсэн гэмт бие хүний объектив талын шинж нь:

1. Олон нийтийн хэв журам зөрчиж байсан бөгөөд танхай балмад зан авир нь дахин дахин илрэн гардаг хүмүүс,
2. Байнга архи дан согтуурагчид буюу мансууруулах бодис хэрэглэгчид,
3. Ажил сургуульгүй, чөлөөт цагаа ямар ч зорилгогүй өнгөрөөгчид,
4. Хүч хэрэглэсэн гэмт хэрэгт өмнө нь шийтгүүлж байсан хүмүүс,
5. Зодооны буюу жижиг танхайн хэрэгт захиргааны арга хэмжээ авагдаж байсан хүмүүс,
6. Биедээ халуун хүйтэн зэвсэг байнга авч яваа хүмүүс зэрэг болно.

Дээрх шинж байдлыг харгалзан үзэж, хүч хэрэглэсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг гурван ангиллаар хийж болно.

1. Гэр ахуй, ажил сургуулийн нөхцөлд бие хүний зан төлөв бүрэлдэн тогтоход сөргөөр нөлөөлж байгаа нөхцөл байдлуудыг арилгах болон хүмүүжлийн зөв замд оруулах аятай таатай нөхцөлийг бүрдүүлэх;
2. Хүч хэрэглэсэн гэмт хэрэг гарах ахуйн орчин, уур амьсгалыг таслан зогсоох, арилгах;
3. Энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн үйлдэх магадлал бүхий хүнийг олж илрүүлэн түүнтэй тулж ажиллах (мэргэжилгүй хүнийг сургалтанд хамруулах, ажлын байр олоход нь туслах, чөлөөт цагаа зөв боловсон үр ашигтай өнгөрөөхөд нь нөлөөлөх гэх мэт).

ХЯНАЛТЫН АСУУЛТ:

- Хууль тогтоомж судлан хүч хэрэглэсэн гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогод дүн шинжилгээ хийнэ үү.
- Орчин цагийн хүч хэрэглэсэн гэмт явдлын шалтгаан нөхцөлийг тодорхойлон ярилцана уу.
- Орчин цагийн хүч хэрэглэсэн гэмт бие хүний криминологи шинжийг тодорхойлон ярилцана уу.
- Хүч хэрэглэсэн гэмт явдалтай тэмцэх ямар арга замыг та үр дүнтэй гэж үзэж байна вэ? Үндэслэлээ тайлбарлан ярилцана уу.



СЭДЭВ 10. ШУНАХАЙ ГЭМТ ЯВДАЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

Сэдвийн зорилго: *Шунахай гэмт явдлын криминологи шинж, хор уршиг, шалтгаан нөхцөл, тусгай шинжийг судлаж, энэ төрлийн гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах чадвар эзэлших.*

Хүний хүсэл хязгааргүй үүний зэрэгцээ ёс суртахууны доголдол хэмээгдэх аливаа материаллаг өмчийг гэмт замаар олж авах гэсэн шунахай сэтгэл бий болно. Үүнийг ерөнхийд нь шунахайн сэдэлттэй гэмт явдал гэж ойлгох нь зүйтэй. Судлаач эрдэмтэд энэхүү гэмт явдлыг янз бүрээр тайлбарласан байдаг. Тухайлбал :

- Шунахай гэмт явдал хэмээх энэ нэр ойлголтод эдийн засгийн гэмт явдал, иргэдийн өмчийн эсрэг гэмт хэргүүд бүхэлдээ багтана.
- Шунахай гэмт явдал нь эдийн засгийн хүрээний харилцааг зөрчөөгүй албан тушаалаа ашиглаагүй байдалд үйлдсэн ба хүний эд хөрөнгийг өөрөө баяжих, ашиглах зорилготой хууль бус ажиллагааны цогц нийлбэр.

Шунахайн сэдэлт нь бусад сэдэлтийн нэгэн адил нийгэм эдийн засаг, зохион байгуулалтын болон сэтгэл зүйн шинжтэй тусгай шалтгааныг цогц байдлаар илэрхийлсэн субъектив тусгалын илэрхийлэл болдог.

Монгол Улсын хэмжээнд түгээмэл үйлдэгдэж байгаа зарим төрлийн шунахайн сэдэлттэй гэмт хэргийн криминологи шинжийг тодорхойлох нь энэ гэмт явдлын үндсэн шинжийг тодорхойлоход зайлшгүй ач холбогдолтой юм. Хулгайн гэмт хэрэг нь манай орны хувьд түгээмэл гардаг бөгөөд судалгаанаас үзэхэд улсын хэмжээнд үйлдэгдэж байгаа нийт гэмт хэргийн 51-55%-ийг эзэлж байжээ.

Шунахай гэмт явдлын хор уршиг:

1. Хүнд ноцтой гэмт хэрэг үйлдэх, зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн гишүүд ихэвчлэн хулгай, дээрэм, булаалтын гэмт хэрэг үйлдэж эхэлдэг;
2. Шунахай гэмт явдал нь даамжирвал хүч хэрэглэсэн гэмт явдлын шалтгаан болж, улмаар иргэд өөрсдийгөө зэвсэглэн хамгаалах үндэсийг бүрдүүлдэг;
3. Шунахайн гэмт бие хүмүүс ажил олдохгүй, ядуу байгаа гэдгээрээ түрий барьж гэмт хэрэг үйлдэх бусад хүмүүсийг гэмт үйлдэлдээ татан оруулдаг;
4. Хүмүүсийн бие биедээ итгэх итгэл алдардаг.

Шунахай гэмт явдлын шалтгаан нь нийгэм эдийн засгийн харилцаанаас үүдэлтэй гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, хувийн өмч хийгээд нийгмийн баялгийн тэгш бус хуваарилалт, төр засгийн бодлого, хууль дүрмийн

зохицуулалт зэрэг нь шууд ба шууд бус байдлаар хүмүүст шунахайн сэдлийг төрүүлж, улмаар гэмт хэрэг, гэмт явдал гаргахад хүргэдэг байна.

Дээр өгүүлсэн об'ектив болон суб'ектив шинжийг агуулсан шунахайн гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг :

- Нийгэм эдийн засгийн тэгш бус байдал,
- Эд материалын гологдол,
- Эдийн засгийн үйл ажиллагаанд тавих нийгэм эрх зүйн хяналтын сул тал,
- Шунахайн сэдэлтэй гэмт хэргийг илрүүлэх, бүртгэх, эрүүгийн хариуцлагад татах явцад хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд гарч байгаа алдаа дутагдал,
- Шунахайн сэдэлтэй гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтын хомсдол, хуулийн хоцрогдол гэсэн байдаг.

Нийгэм эдийн засгийн тэгш бус байдал шунахайн гэмт явдлын гаралтад нөлөөлдөг. Хэрвээ хэрэгцээ ба гуйланчлал нь үгээгүй ядуучуудыг гэмт хэрэгт түлхдэг бол нийгэм эдийн засгийн тэгш бус байдлаар нөхцөлдсөн баяжих гэсэн шунал нь чинээлэг хэсгийнхнийг гэмт хэрэгт илүүтэй түлхэж байдаг.

Шунахайн сэдэлтэй гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь зах зээлийн харилцааны үндэс болсон янз бүрийн үзэгдлүүдийг заавал хөндөх болдог онцлогтой. Тиймээс гэмт явдлын үндсэн шалтгаан оршиж байдаг нийгэм эдийн засгийн байгууллагыг бэхжүүлэх, энэ байгууллагыг төрийн болон төрөөс явуулж байгаа нийгэмийн хүрээний бүх хүчээр хамгаалах, дэмжих, гэмт явдлын үндсэн суурь шалтгаануудыг арилгахад чиглэгдсэн арга хэмжээнүүдийг бүрэн дүүрэн үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Нөгөөтэйгүүр энэ гэмт явдал нь ердийн болон зохион байгуулалттай гэмт хэргийн хамгийн олон төрлийн хэлбэрийг хамарч эрчимтэй өсч байгаа юм.

Ер нь урьдчилан сэргийлэх талаар зохиож байгаа арга хэмжээний агуулга, цар хүрээ нь шунахайн сэдэлтэй гэмт явдал гаргах шалтгаан нөхцөлийн агуулгад нийцэж байх нь уг ажиллагааны үр дүнгийн чухал шалгуур байдаг. Иймд шунахайн сэдэлтэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд нь нийгэм, эдийн засаг, улс төр, зохион байгуулалт эрх зүй, техникийн болон хүмүүсийн шинж чанартай байж болно.

Шунахайн сэдэлтэй гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэл нь юуны өмнө нийгмийн амьдралын суурь асуудлыг зохистой шийдвэрлэх явдалтай холбоотой. Гэхдээ урьдчилан сэргийлэх арга хэмжээний түүхээс үзвэл эдгээр асуудлыг бүрэн гүйцэт шийдвэрлэх өөрөөр хэлбэл эд материал үнэт зүйлсийн төлөө хууль бусаар шунан тэмүүлэх явдлыг ор үндэсгүй болгох тийм сонгодог арга одоохондоо алга байна. Ийм учраас эдийн засгийн хөгжил дэвшил болон хувийн өмчийг, хүмүүсийн нийгмийн хамгааллыг сайжруулан



хөгжүүлэх явдалтай их бага хэмжээгээр тал бүрээр хослуулсан оновчтой шийдвэрлэх талаар ярих нь чухал юм.

Манай орон өмч хувьчлалыг ухаалаг, зөв, шударга явуулж чадаагүйгээс хүмүүсийн амьжиргааны түвшинд эрс ялгаа гарч тэр нь нийгмийн баян ядуугийн ихээхэн ялгаатай давхрагыг үүсгэсэн явдал бол шунахайн сэдэлтэй гэмт явдлын хөрс суурь нь болно. Нийгмийн ийм тэгш бус байдлыг эрх зүйн хувьд зохицуулахад төрөөс ихээхэн хүч шаардана.

Улс оронд нийгэмд тогтсон тэгш биш байдлыг туйлын багасгах, зохистой хэмжээнд хүргэх нь нийгэм эдийн засгийн талаарх төрийн бодлогын эн тэргүүний чиглэлийн нэг байхаас гадна шунахайн сэдэлтэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй алс хэтийн бодлогын нэгээхэн хэсэг байвал зохино. Аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд нийт иргэдэд эн тэнцүү боломж олгосноор эдийн засгийн хувьд идэвхтэй хууль ёсыг сахин хүндэтгэдэг бөгөөд эд материалын хувьд чинээлэг хүмүүсийн тоог нэмэгдүүлдэг. Төрөөс зохицуулан хэрэгжүүлэх энэ мэт арга хэмжээ нь эцсийн эцэст нийгмийн тэгш бус байдлыг арилгахад чиглэгдэх ёстой.

Шунахайн сэдэлтэй гэмт явдлаас урьдчилан сэргийлэх өөр нэг цогц арга хэмжээ нь хүн амын нийгмийн хамгааллын арга хэмжээг дэс дараатай шийдвэрлэж тэднийг эд материалын хүнд гачигдлаас болон ядуурлаас ангижруулах явдал юм. Ийм арга хэмжээнүүдэд юуны өмнө улсын төсвийн талаар наад захын эмх цэгц тогтоох, төрийн зохицуулалттайгаар баталсан улсын төсвийг үр ашигтайгаар зарцуулах, хүн амын ядуурлын доод үе давхаргад нийтээр нь буюу нэг бүрчлэн хамгаалах асуудлууд орно. Тухайлбал:

- Цалин хөлсийг цаг тухайд нь олгож, улс орны инфляцийн түвшингээс түрүүлж цалинг аажмаар нэмэгдүүлэх;
- Бүх төрлийн тэтгэврийн насныхан болон боломжийн хэмжээгээр амь зуухуйц хэмжээнд байхын тулд өндөр настнууд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэтгэвэр тэтгэмжийг нийгмийн шаардлагатай түвшинд хүртэл нэмэгдүүлэх;
- Төрийн зүгээс гэр бүлийн талаар явуулах бодлогыг боловсронгуй болгож, айл өрхүүд ялангуяа, эцэг эхийн асрамж хамгааллаас гадуурх хүүхдүүдэд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах;
- Олон хүүхэдтэй өрхүүдэд олгох тэтгэлгийг нэмэгдүүлэх;
- Хөрөнгө чинээгээр дорой өрхүүдийн орон сууцны асуудлыг аажмаар шийдвэрлэх;
- Хүн амын ажил эрхлэлтийн асуудлыг шийдвэрлэх;
- Ажилгүйдлийг бууруулж зайлшгүй шаардлагатай тэтгэмжээр хангах;
- Байгалийн болон гал усны аюулд нэрвэгдэгсдэд эд материалын бодитой тусламж үзүүлэх;
- Ядуучуудад зориулж тэтгэмж үзүүлдэг байгууллагуудыг төрийн зүгээс урамшуулах зэрэг болно.

ХЯНАЛТЫН АСУУЛТ:

- Хууль тогтоомж судлан шунахайн гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогод дүн шинжилгээ хийнэ үү.
- Орчин цагийн хүч хэрэглэсэн шунахайн гэмт явдлын шалтгаан нөхцөлийг тодорхойлон ярилцана уу.
- Орчин цагийн шунахайн гэмт бие хүний криминологи шинжийг тодорхойлон ярилцана уу.
- Шунахайн гэмт явдалтай тэмцэх ямар арга замыг та үр дүнтэй гэж үзэж байна вэ? Үндэслэлээ тайлбарлан ярилцана уу.



СЭДЭВ 11. ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ЯВДАЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

Сэдвийн зорилго: *Зохион байгуулалттай гэмт явдлын криминологи шинж, хор уршиг, шалтгаан нөхцөл, тусгай шинжийг судлаж, энэ төрлийн гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах чадвар эзэлших.*

Гэмт явдал нь өөртөө зохион байгуулалт гэх криминал шинж, дотоод шалтгааныг агуулдаг. Өөрөөр хэлбэл, аливаа гэмт хэрэг нь давтан үйлдэгдэх (recidivism), улам бүр мэргэших (professionalism), эргэх нөлөө (retroactivity), зохион байгуулалттай болох (staying organized) гэсэн дотоод шалтгааныг өөртөө нөхцөлдүүлсэн байдаг. Энэхүү дотоод шалтгааны нэг болох гэмт явдлын зохион байгуулалттай болох шинж нь зохион байгуулалттай гэмт явдлын орчин хандлагыг тодорхойлж байна.

Аливаа гэмт этгээд уг гэмт хэргийн улмаас олж авах ашиг орлогоо нэмэгдүүлэх, эрүүгийн хариуцлагаас зайлсхийх, хууль сахиулах байгууллагын эсрэг зогсох хүчтэй байх, гэмт хэргээ саадгүй үйлдэх зэрэг асар олон шалтгааны улмаас гэмт хэргийг дахин давтан үйлдэх тутамдаа гэмт хэргийн зохион байгуулалттай бүлэг байгуулах хэрэгцээг ухамсарлаж, энэхүү ашиг сонирхол нь гэмт этгээдүүдийг хоорондоо нэгдэж нягтрах, зохион байгуулалтад орж үйл ажиллагаа явуулахад түлхэж байдаг юм.

Зохион байгуулалттай гэмт явдал гэх үзэгдэл нь нийгмийн хөгжлийг даган эрчимтэй хувьсаж өдгөө эл ухагдахууны хүрээнд гурван түвшний үзэгдэл, үйл явцыг хамааруулж үзэх шаардлагатай болоод байна.

Эхний түвшинд гэмт этгээдүүд тодорхой гэмт хэрэг үйлдэж ашиг олох зорилгоор тодорхой нэг удирдагч, нөлөө бүхий гэмт хэрэгтэний санаачилга, удирдлага доор нэгдэж зохион байгуулалттай бүлэг үүсгэх үзэгдэл илэрч үүнийг судлаачид жижиг бүлэг, гэмт этгээдүүдийн бүлэглэл гэх мэтээр нэрлэж байна. Ийм төрлийн жижиг бүлгийн гол онцлог нь тэрхүү бүлгийг нэгтгэн удирдах толгойлогчийн санаачилга, үйл ажиллагаанаас шууд хамааралтай, толгойлогчийн удирдан зохион байгуулах байдал, гэмт бүлгийг нэгтгэж, нягтруулах чадвараас хамааралтай байдаг явдал юм.

Гол төлөв онц аюултай гэмт хэрэгтэн, мэргэжлийн гэмт хэрэгтэнүүд ийм жижиг бүлгүүдийг үүсгэн удирдаж байдаг. Олон жил хорих ял шийтгэгдэж нийгмийн орчноос удаан хугацаагаар тусгаарлагдсан мэргэжлийн болон онц аюултай гэмт хэрэгтэнүүд хорих байгууллагаас суллагдаад нийгэмд гарахад өөрийн гэх найз нөхдийн хүрээлэл байхгүй, ажил эрхэлж амьдрах боломжгүй болж, нийгмийн харилцаанаас тусгаарлагдсан байдаг зэрэг олон шалтгааны улмаас онц аюултай гэмт хэрэгтэн, мэргэжлийн гэмт хэрэгтнүүд өөрийн

гэх хүрээллийг бий болгож, гэмт этгээдүүдийг удирдан зохион байгуулах сонирхолтой байдаг. Энэ нь нэг талаар тэр хүний нийгмийн хэрэгцээ, нөгөө талаар гэмт хэрэг үйлдэж ашиг орлого олж амьдрах эх үүсвэр олох гэсэн эдийн засгийн хэрэгцээ зэргээс нөхцөлдсөн байдаг. Ийнхүү хэн нэгэн нөлөө бүхий гэмт хэрэгтэний санаачилга, манлайллаар байгуулагдсан гэмт бүлэг нь тэрхүү гэмт хэрэгтэнээс шууд хамааралтай, удирдан зохион байгуулагч нь ял шийтгэгдэх, нас барах зэрэг ямар нэгэн шалтгаанаар бүлгийг нэгтгэж, нягтруулах боломжгүй болсон үед задран алга болдог онцлогтой байдаг. Мөн иймэрхүү хэн нэгний санаачилгаар байгуулагдсан бүлэг нь тухайн хүний бусадтай харилцах боломжоос шууд хамааралтай байдаг учир төдийлөн олон хүнийг нэгтгэн зохион байгуулсан шинжтэй байдаггүй. Ийм байдлаар зохион байгуулалттай гэмт явдал хэмээх үзэгдлийн энгийн хэлбэр буюу жижиг гэмт бүлгүүд үүссэн байдаг ажээ.

Зохион байгуулалттай гэмт явдлын хандлага

Зохион байгуулалттай гэмт үйл ажиллагааны өөрчлөгдөж буй чиглэл

Уламжлалт:

- Мансууруулах бодисын наймаа,
- Хүн худалдаалах гэмт үйл ажиллагаа ихээр үйлдэгдэж байгаагийн зэрэгцээ.

Шинээр:

- Аж ахуйн үйл ажиллагаагаар халхлан хориглосон үйлдвэр, үйл ажиллагаа эрхлэх,
- Санхүүгийн хууль бус операци явуулах,
- Контрабанд (зэвсэг, үнэт эдлэл, хууль бус ан, шинэ технологи) зэрэг гэмт үйл ажиллагаа идэвхтэй явуулах болсон.

Зохион байгуулалттай гэмт явдлын хандлага

- Зохион байгуулалттай гэмт явдал нь нийгмийн хөгжлийн төлөв хандлагыг даган өөрчлөгдөж,
- Гэмт бүлэглэлийн,
- Гэмт байгууллагын,
- Гэмт сүлжээний хэлбэрээр үйлдэгдэж тус бүрийн онцлог криминал шинжтэйгээр нийгэмд оршин тогтнох болжээ.

Ялангуяа, сүүлийн жилүүдэд гэмт байгууллагууд даяаршин буй дэлхий дахинаа тархсан гэмт хэргийн сүлжээ үүсгэж өөрсдийн гишүүдээр бус улс орон дахь гэмт хэрэгтэнүүдийг холбосон сүлжээгээр гэмт үйл ажиллагаа явуулах хандлага ажиглагдах болжээ.



Орчин үеийн криминологид зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэх стратегид

- гэмт хэргийн эрсдэл болон өртгийг нэмэгдүүлж ашгийг,
- үе шат бүхэнд илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, олон талт хамтын ажиллагаа,
- үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт явдлын эсрэг улс үндэстнүүдийн хамтарсан бодлого, хамтын ажиллагаа чухал болоод байна.

Зохион байгуулалттай гэмт явдлын хор уршиг:

Тухайн гэмт хэргийг илрүүлэхэд бусад тодорхой төрлийн гэмт явдалтай тэмцэхээс илүү их зардал гарахаас гадна хууль сахиулах байгууллагын ажилтан, жирийн иргэдийн амь нас эрсдэх бодит нөхцөлийг бүрдүүлдэг.

1. Гэмт хэрэгтэн төдийгүй гэмт бие хүмүүсийг нэгтгэн мэргэшүүлж улмаар “төр доторх төр” гэсэн ойлголтыг бий болгоно;
2. Тухайн улсад хууль тогтоомжийн хэрэгжилт муудаж иргэд төрдөө итгэх итгэл буурна;
3. Төрийг ард түмэн бус гэмт бүлэглэлүүд хяналтандаа авах эрсдэл бий болно.

ХЯНАЛТЫН АСУУЛТ:

- Хууль тогтоомж судлан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогод дүн шинжилгээ хийнэ үү.
- Орчин цагийн хүч хэрэглэсэн зохион байгуулалттай гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тодорхойлон ярилцана уу.
- Зохион байгуулалттай гэмт явдлыг ангилан төрөлжүүлж тэдгээрийн хор уршиг, тэмцэх арга замын талаар ярилцана уу.
- Шунахай гэмт явдалтай тэмцэх ямар арга замыг та үр дүнтэй гэж үзэж байна вэ? Үндэслэлээ тайлбарлан ярилцана уу.

СЭДЭВ 12. ХҮҮХДИЙН ГЭМТ ЯВДАЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

Сэдвийн зорилго: *Хүүхдийн гэмт явдлын криминологи шинж, хор уршиг, шалтгаан нөхцөл, тусгай шинжийг судлаж, энэ төрлийн гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах чадвар эзэлших.*

Хүүхдийн гэмт явдлын криминологи шинж:

Хүүхдийн гэмт явдлыг дараах байдлаар ангилж судалж болно.

1. Бага насны хүүхдийн (14 нас хүртэлх),
2. Дунд насны хүүхдийн (14-16 нас),
3. Өсвөр насны (16-18 нас).

Ял шийтгэл оногдуулж болох нас хүрсэн тохиолдолд гэмт хэрэг, буюу гэмт хэрэгтэн гэж үзэж судлах уламжлалт ойлголтоо өргөтгөн хүүхдийн үйлдэж буй гэмт хэргийг бүхэлд нь судлах нь тэдгээрт хариуцлага хүлээлгэх бус тухайн үзэгдлийн мөн чанарыг судалж урьдчилан сэргийлэх зорилго агуулдаг.

Хүүхдийн гэмт явдлын онцлог:

- Дээрэм, булаах, хулгайлах гэмт хэрэг голдуу үйлддэг,
- Бүлэглэж үйлддэг,
- Хуульд заасан ял шийтгэл оноох насанд хүрэхээсээ өмнө гэмт хэрэг үйлдсэн байдаг,
- Бусдыг даган дууриах буюу бусдадаа зааж гэмт хэрэг үйлддэг.

Хүүхдийн гэмт явдлын хор уршиг:

1. Бусад хүүхдүүдийг нийгэмд харш зан үйлд уруу татдаг,
2. Хүүхэд насаа нийгмийн сөрөг соёлд өнгөрөөж түүндээ дасч улмаар рецидив гэмт бие хүн болон төлөвшдөг,
3. Нийгмийн сэтгэл зүйд нөлөөлдөг.

Насанд хүрээгүй гэмт бие хүний криминологи шинж

Насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүдэд түгээмэл байдаг онцлог шинжүүд:

- ёс суртахуун, зан төлөвийн хувьд доголдолтой, тэр байдал нь амьдрал, үйл хөдлөл дээр нь байнга илэрч байдаг (харааж, зүхэх, бусдыг доромжлох, хэнийг ч үл тоомсорлох, өмч эд зүйлийн эвдэж гэмтээх гэх мэт),
- мөрийтэй тоглоом тоглох, согтууруулах ундаа хэрэглэх, зан заншлыг үл тоомсорлох,
- сургалт хүмүүжлийн болон албан газар, гэрээсээ оргон зайлах, тэнэмэл байдлаар амьдрах,



- бэлгийн харьцаанд эрт орох, бэлгийн замбараагүй амьдралд дасах,
- хүчирхийлэх зан төлөвийн үйлдлүүд хийх, бүдүүлэг авирлах, өш хонзон авах, хорон муу санах,
- эцэг эх болон гэр бүлийн бусад гишүүдийг заналхийлэх, гэр бүлд байнгын хэрүүлтэй байх, зөрчилтэй нөхцөлийг сөдөөгч байх,
- сахилга сайтай, сурлагын амжилтаар сайн хүүхдүүдэд атаархах, дайсагнах хандлага гаргах,
- муу зүйлийг тусгах, сурч авахад хурдан түүнийгээ даруй хэрэгжүүлдэг гэх мэт онцлогууд байна.

Насанд хүрээгүй гэмт бие хүний сэтгэл зүйн онцлог

Насанд хүрээгүйчүүдийн гэмт явдал нь гадаад орчны сөрөг хүчин зүйлс (гэр бүл, хамт олон, бичил бүлэглэлийн харш нөлөөлөл), тэдний зан төлөв сэтгэл зүйн онцлогуудын харилцан үйлчлэлийн шууд үр дүн юм.

Эцэг, эхийн хараа хяналтаас гарсан, байнгын хэрүүл маргаан, зөрчилтэй, эрүүл бус уур амьсгалтай гэр бүлд өсөж хүмүүжсэн хүүхдүүд гэр бүлээсээ дайжин явж хүмүүжлийн доголдол, зан суртахууны эвдрэлд автан гэмт хэргийн замд ордог болохыг тогтоосон байна.

Насанд хүрээгүй хүүхдүүд дүрсгүйтэх, романтик байдлаар амьдрах, насанд хүрсэн хүний амьдралаар амьдрахыг яарах, эрмэлзэх, шохоорхох, өөрийгөө аймшиггүй зориг зүрхтэй болгож бусдад харуулах гэсэн хүсэлд хөтлөгдөн нийгмийн хор аюул багатай гэмт хэрэг үйлдэж эхэлдэг.

Хүүхдийн гэмт явдлын шалтгаан нөхцөл

Ажил, сургуульгүйгээсээ болоод өөрийн хүссэн, сонирхсон мэргэжлээ эзэмшиж ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй болсон насанд хүрээгүй хүмүүсийн тоо нэмэгдсэн нь тэднийг гэмт хэрэгт татан оруулах олон хүчин зүйл байдаг. Үүнийг хоёр хэсэгт хувааж үзэж болох юм.

1. Нийгэм - хүн ам зүйн хүчин зүйл.

- Нийгэм эдийн засгийн ерөнхий хүчин зүйл,
- Ажилгүйдэл, ядуурал,
- Сургууль завсардалт.

2. Нийгэм эдийн засгийн шинжтэй хүчин зүйл

- Тэнүүлчлэл,
- Гэр бүлийн орчин,
- Үе тэнгийнхний нөлөө,
- Томчууд хүүхдийн харилцаа,
- Хэвлэл мэдээлэл,
- Гэмт хэрэгтэй тэмцэх арга механизм, тогтолцоо гэж тус тус тоймлон авч үзэж болох юм.

Хүүхдийн гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга зам

Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт явдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зөв зүйтэй, сайтар боловсруулсан төлөвлөлтийн дагуу явуулснаар нийгмийн харилцаа эрүүл зөв тогтолцоотой болоход нааштай үр дүн гарна. Гэмт явдал судлалд насанд хүрээгүй этгээдийн гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дараах асуудлуудыг хамруулан авч үзэх чиглэл байдаг.

ХЯНАЛТЫН АСУУЛТ:

- Хууль тогтоомж судлан хүүхдийн гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогод дүн шинжилгээ хийнэ үү.
- Орчин цагийн хүүхдийн гэмт явдлын шалтгаан нөхцөлийг тодорхойлон ярилцана уу.
- Хүүхдийн гэмт явдлыг ангилан төрөлжүүлж тэдгээрийн хор уршиг, тэмцэх арга замын талаар ярилцана уу.
- Хүүхдийн гэмт явдалтай тэмцэх ямар арга замыг та үр дүнтэй гэж үзэж байна вэ? Үндэслэлээ тайлбарлан ярилцана уу.